



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,  
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№ 1976 оны 4-р сар № 4 / 47/

## ГАРЧИГ

### I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |     |   |     |
|-----|---|-----|
| 1.  | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай                  | 373 |
| 2.  | Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн зарим заалтыг өөрчлөлт оруулах тухай             | 374 |
| 3.  | Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                           | 374 |
| 4.  | Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай   | 378 |
| 5.  | Хэлэлцээр соёрхон батлах тухай  | 378 |
| 6.  | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 379 |
| 7.  | Гэрээ соёрхон батлах тухай  | 380 |
| 8.  | Хэлэлцээр соёрхон батлах тухай  | 380 |
| 9.  | Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай              | 381 |
| 10. | Иргэний хамгаалалтын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай                    | 381 |
| 11. | Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                                    | 382 |
| 12. | Хэлэлцээр соёрхон батлах тухай  | 382 |
| 13. | Хэлэлцээр соёрхон батлах тухай  | 383 |

### II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |     |                        |     |
|-----|------------------------|-----|
| 14. | Дүрэм батлах тухай №05 | 384 |
|-----|------------------------|-----|

15.	Ж.Бямбажавыг Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр томилох тухай №08	389
16.	Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл тогтоох тухай №09	389
17.	Нийгмийн даатгалын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №10	390
18.	Монгол Улсын Их Хурлын 1996 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай №11	391

### III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

19.	Ж.Олзбайд Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгох тухай №18	392
20.	Журам батлах тухай №19	392
21.	М.Албанчид Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгох тухай №20	398
22.	С.Дэвинпилд Монгол Улсын гавьяат агрономч цол олгох тухай №21	399
23.	Д.Батчулууныг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай №22	399
24.	Ж.Лхагвыг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай №23	400
25.	Журам батлах тухай №26	400

### IV. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

26.	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны сурагчдын хоол хүнс, ахуйн хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай №175	405
27.	Эрчим хүч, геологи, уул уурхайн улсын хяналтын дүрэм батлах тухай №190	407
28.	Боловсролын улсын хяналтын дүрэм батлах тухай №191	415
29.	Эрүүл ахуй, халдвар судлал, эм, биобэдлэмэлийн улсын хяналтын дүрэм батлах тухай №192	420
30.	Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм батлах тухай №193	432
31.	Журам батлах тухай №194	438
32.	Иргэний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын талаар авах зарим арга хэмжээний тухай №195	446
33.	Хүүхдийн зарим сонин, сэтгүүлийн талаар авах арга хэмжээний тухай №196	447
34.	Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай №198	448
35.	Тогтоолын заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, журам батлах тухай №208	449
36.	Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын дүрэм батлах тухай №210	453

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ**

1995 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

“ 58 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн  
хураамжийг хуваарилах

Улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдоод хуваарилан хариуцуулах асуудлыг энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасны адилаар зохицуулна.”

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “шүүхийн шийдвэр” гэснийг “шүүхийн болон арбитрын шийдвэр”, “шүүхийн тогтоол” гэснийг “шүүхийн болон арбитрын тогтоол” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “57”, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт...” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийг хүчингүй болгосугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ**

1996 оны 1 дүгээр  
сарын 11-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ  
ЗААЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"1/ Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1,2-г дурдагдсан шийдвэрийг батлан гаргахад таслах эрхтэйгээр оролцсоноос хойш 2 жил өнгөрөөгүй бол;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

**Ж. ГОМБОЖАВ**

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ**

1996 оны 1 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Нэгдүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн эхний өгүүлбэр, 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь заалт, 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг:

"1.Сонгуулийг нэг мандаг бүхий тойргоор зохион байгуулж явуулна.

2. Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна. Аймагийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно."

2/21 дүгээр зүйлийн 1,5 дахь хэсэг:

"1.Сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчид өөрийн мөрийн хөтөлбөр, үзэл бодлоо чөлөөтэй тайлбарлан таниулах, нэр дэвшигчдээ сурталчлах зорилгоор хурал цуглаан хийх, уулзалт зохион байгуулах, ухуулах байр ажиллуулах эрхтэй.

Нам, эвсэл, бие длац нэр дэвшигчийн сонгуулийн өмнөх сурталчилгааны зориулалттай уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлал зэргийг аймагт сумын Засаг дарга, нийслэлд дүүргийн Засаг даргаас зөвшөөрсөн гудамж, талбай болон олон нийтийн газарт байрлуулна.

5.Удс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно."

3/33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн эхний өгүүлбэр:

"3.Саналын хуудсанд нэр дэвшигчийн овог, нэрийг нам, эвсэлээр нь дараалан бичиж хэвлэнэ."

4/35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Сонгогч саналын хуудсыг авч санал бэлтгэх тасалгаанд орж, уг хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн зөвхөн нэг нэр дэвшигчийн овог, нэрийн өмнөх дугаарыг дугуйлан тэмдэглээд саналын хайрцагт хийнэ."

5/36 дугаар зүйлийн 3 дахь заалт:

"3.Санал огт тэмдэглээгүй буюу мандатын тооноос илүү тэмдэглэсэн, энэ хуульд зааснаас өөр ямар нэг тэмдэглэл хийсэн;"

6/38 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Тухайн тойрогт хамгийн олон гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнд сонгогдсонд тооно.

Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг саналын хуудсанд үлдээж, дахин санал авна. Дахин санал авалтыг энэ хуудийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар явуулна. Дахин санал авалтаар тухайн хоёр нэр дэвшигчийн хэн нь ч сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авч чадаагүй бол энэ хуулийн дагуу дахин сонгууль явуулна."

7/42 дугаар зүйл:

"42 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүнийг нөхөн сонгох

1.Улсын Их Хурлын гишүүн нас барсан, хүсэлтээрээ гишүүний үүргээс чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүдэн татсан бол Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг Улсын Их Хурлын гишүүнийг орон гарснаас хойш Улсын Их Хурал 14 хоногийн дотор зарлаж, 45 хоногийн хугацаанд багтаан явуулна.

2. Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль явуулахад энэ хуулийн холбогдох заалтыг баримтлах бөгөөд нөхөн сонгуулийн арга хэмжээг дор дурдсан хугацаанд зохион байгуулна:

1) сонгуулийн тойргийг санал авах өдрөөс 40 хоногийн өмнө, сонгуулийн хэсгийг 35 хоногийн өмнө, тойргийн салбар хороог 25 хоногийн өмнө, сонгуулийн хэсгийн хороог 25 хоногийн өмнө тус тус байгуулна;

2) нэр дэвшүүлэх ажлыг нөхөн сонгууль зарласнаас хойш 10 хоногийн дараа эхэлж, 15 хоногийн хугацаанд дуусгана. Нөхөн нэр дэвшүүлэх үйл ажиллагааг дээрх хугацаанд багтаана;

3) сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасан журмын дагуу үйлдэж, санал авах өдрөөс 20 хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороонд өгнө. Хэсгийн хороо энэхүү жагсаалтыг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө сонгогчлод ил танина.

3.Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

4. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахад 1 жил хүрэхгүй хугацаа үлдсэн бол нөхөн сонгохгүй."

Хоёрдугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "2000-5000 хүртэл төгрөгөөр" гэснийг "50,0 мянга хүртэл төгрөгөөр", 4 дэх хэсгийн "2000 хүртэл төгрөгөөр" гэснийг "50,0 мянга хүртэл төгрөгөөр", 5 дахь хэсгийн "50,0 мянга хүртэл төгрөгөөр" гэснийг "250,0 мянга хүртэл төгрөгөөр", "2000-5000 хүртэл төгрөгөөр" гэснийг "50,0 мянга хүртэл төгрөгөөр", 6 дахь хэсгийн "50,0 мянга хүртэл төгрөгөөр" гэснийг "250,0 мянга хүртэл төгрөгөөр", "2000-5000 хүртэл төгрөгөөр" гэснийг "50,0 мянга хүртэл төгрөгөөр", 7 дахь хэсгийн "2000 хүртэл төгрөгөөр" гэснийг "10,0 мянга хүртэл төгрөгөөр", 8 дахь хэсгийн "50,0 мянга хүртэл төгрөгөөр" гэснийг "250,0 мянга хүртэл төгрөгөөр", 9 дэх хэсгийн "2000-5000 хүртэл төгрөгөөр" гэснийг "50,0 мянга хүртэл төгрөгөөр", 10 дахь хэсгийн "500-2000 хүртэл төгрөгөөр" гэснийг "10,0 мянга хүртэл төгрөгөөр" гэж, 25 дугаар зүйлийн "1000 төгрөгийг" гэснийг "10000 төгрөгийг" гэж, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "төв" гэснийг "төвийн" гэж, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "дүүрэг" гэснийг "дүүргийн" гэж, 38 дугаар зүйлийн 4,5 дахь хэсгийг 5,6 дахь хэсэг гэж тус тус өөрчилсүгэй.

Гуравдугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль дараахь агуулга бүхий зүйл, заалт нэмсүгэй:

1)5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

"10. Улсын Их Хуралд суудал бүхий намуудад авсан суудлын тоог баримтлан улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Санхүүжилтийн хэмжээ, олгох журмыг Улсын Их Хурал тогтооно."

2)6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "2" гэсний өмнө"1,"

3)24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлдэр:

"Сонгогч-дэмжигчид нь аймагт тухайн тойргийн сум бүрээс, нийслэлд тухайн тойргийн хороо бүрээс оролцсон төлөөлөлтэй байна."

4)38 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Дэхин санал авах ажлыг сонгууль болсон өдрөөс хойш 14 соногийн дотор багтаан явуулна."

Дөрөвдүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 3,10 дугаар зүйлийн 2, 13 дугаар зүйлийн 2,32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурасан "гэдгээртэй (гүүнтэй) адилтгах

засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн (нэгж)" гэснийг, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "(гүйцэтгэх захиргаа)" гэснийг, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "ногодох мандатын тоог" гэснийг, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Энэхүү сурталчилгааны төлбөр нь рекламн төлбөрийн дундажийн 50 хувиас хэтрэхгүй байна." гэснийг тус тус хассугай.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

**Ж.ГОМБОЖАВ**

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 2 дахь хэсэг нэмсүгэй:

"2.Улсын хилд хил хамгаалах албан үүргээ биэчлэн гүйцэтгэж байгаа иргэн гэмт халдлагын улмаас амь насаа алдав түүний гэр бүлд энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно."

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

**Ж.ГОМБОЖАВ**

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Брюссель хотноо 1995 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж



ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Бельгийн Ванг Улсын хоорондын Хэлэлцээр"-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их  
Хурлын дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1,4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1/5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "даатгуулагчийн" гэсний дараа "нийгмийн даатгалын шимтгэл төлсөн," мөн зүйлийн 4 дэх хэсгийн "Өндөр насны" гэсний дараа "бүрэн", "75 хувиас" гэсний дараа "хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь мөн хөлсний 50 хувиас тус тус" гэж нэмэх;

2/9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг "Тахир дутуугийн бүрэн тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээтэй, тахир дутуугийн хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээтэй тус тус адил байна" гэж өөрчлөн найруулах;

3/14 дүгээр зүйлд "Тэжээгцээ алдсаны бүрэн тэтгэврийн доод хэмжээг хөдөлмөрийн чадваргүй 1 хүнд хөдөлмөрийн баталгаат хөлсний 50 хувиар, 2 хүнд 75 хувиар, 3 ба түүнээс дээш хүнд 100 хувиар тус тус тогтооно. Харин тэжээгцээ алдсаны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь мөн хөлсний 50 хувиас багагүй байна." гэсэн 3 дахь хэсэг нэмэх;

4/28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө өндөр насны болон тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөр эрхэлж байгаа иргэн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 2-оос доошгүй жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн." гэсэн 3 дахь заалт нэмэх.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар 1995 онд тэтгэвэр тогтоогдсон иргэдийн бүрэн тэтгэвэр нь энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 3,4-г заасан тэтгэврийн доод хэмжээнээс бага байвал тэдний тэтгэврийг энэ хуульд нийцүүлэн өөрчлөн тогтооно.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д "хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь мөн хөлсний 50 хувиас" гэснийг буцаан хэрэглэхгүй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан "Монгол Улс, Бүгд Найрамдах Болгар Улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ"-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Түмэн Голын Эдийн Засгийн Хөгжлийн Бүс, Зүүн Хойт Азийг Хөгжүүлэх Зөвлөлдөх Комитсе байгуулах тухай хэлэлцээр, Түмэн Голын Эдийн Засгийн Хөгжлийн Бүс, Зүүн хойт Азийг хамрах Байгаль Орчны зарчмын талаархи харилцан

ойлголцлын тухай Санамж Бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ**

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫГ  
ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн төгсгөлийн "нэгдэлдээ ажилласан" гэсний дараа "байлдагч, түрүүчээр цэргийн жинхэнэ алба хаасан" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Энэ хуулийг буцааж хэрэглэнэ.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ**

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД  
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Иргэний хамгаалалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ**

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн "бүрэлдэхүүн" гэсний дараа "дээд хэмжээ," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "3 хүртэл сарын" гэснийг "6 хүртэл сарын" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

**Ж.ГОМБОЖАВ**

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ**

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Куала Лумпур хотноо 1995 оны 7 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурсан "Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Малайз Улсын хоорондын Хэлэлцээр"-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

**Ж.ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улаанбаатар хотноо 1995 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан "Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хоорондын Хэлэлцээр"-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын  
эд дарга

**Ж. ГОМБОЖАВ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 1 дүгээр  
сарын 19-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

Монгол Улсын Их Хурлын  
1996 оны 5 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗЭРЭГ ДЭВИЙН ТУХАЙ ДҮРЭМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрэм нь шүүгчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгох, бууруулах, хүчингүй болсонд тооцох журмыг тогтооно.

2. Монгол Улсын шүүхийн шүүгчид шүүхийн тэргүүн түшээ, дэд түшээ, гутгаар түшээ, дөтгөөр түшээ, таадугаар түшээ гэсэн зэрэг дэв олгоно.

3. Шүүгчид зэрэг дэв олгохдоо албан тушаал, шүүгчээр ажилласан хугацаа, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзана.

4. Зэрэг дэв хүртсэн шүүгчид энэ дүрэмд заасан зэрэг дэвийн нэмэгдэл олгоно.

**ХОЁР. Шүүгчид зэрэг дэв олгох, бууруулах, хүчингүй болсонд тооцох журам**

5. Монгол Улсын шүүхийн шүүгчийн зэрэг дэвийг албан тушаал, шүүгчээр ажилласан хугацаа, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар, ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзан дараахь журмаар олгоно:

Зэрэг дэв	Зэрэг дэв олгоход харгалзах нөхцөлүүд				
	Албан тушаал	Ажилласан хугацаа		Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар	Ёс зүйн хэм хэмжээний сахилт
		Шүүгч ээр	Үүнээс Тухайн албан тушаала		
Тэргүүн түшээ	Дээд шүүхийн Ерөнхий шүүгч	10	6		
	Дээд шүүхийн танхумын тэргүүн шүүгч	14	12		
	Дээд шүүхийн шүүгч	20	12	Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын дүгнэлтээр 4-өөс дээш үнэлгээ авсан	Сахилгын болон захиргааны шийтгэл сүүлийн 2 жилд хүлээгээгүй
Дэд түшээ	Дээд шүүхийн Ерөнхий шүүгч				
	Дээд шүүхийн танхумын тэргүүн шүүгч				

	Дээд шүүхийн шүүгч	14	6		Сахилгын болон захиргааны шийтгэл сүүлийн 2 жилд хүлээгээгүй
	Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	16	12	Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын дүгнэлтээр 4-өөс дээш үнэлгээ авсан	Сахилгын болон захиргааны шийтгэл сүүлийн 2 жилд хүлээгээгүй
	Аймаг, нийслэлийн шүүхийн шүүгч	18	12	Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын дүгнэлтээр 4-өөс дээш үнэлгээ авсан	Сахилгын болон захиргааны шийтгэл сүүлийн 2 жилд хүлээгээгүй
Гутгаар түшээ	Дээд шүүхийн шүүгч				
	Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	10	6		
	Аймаг, нийслэлийн шүүхийн шүүгч	12	6		Сахилгын болон захиргааны шийтгэл сүүлийн 2 жилд хүлээгээгүй
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	14	12	Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын дүгнэлтээр 4-өөс дээш үнэлгээ авсан	



	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч	16		Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чад- варын дүгнэлтээр 4-оос дээш үнэлгээ авсан	Сахилгын болон захиргааны шийтгэл сүүлийн 2 жилд хүлээгээгүй
Дот- гоор түшээ	Аймаг, нийслэл- лийн шүүхийн Ерөнхий шүүгч				
	Аймаг, нийслэл- лийн шүүхийн шүүгч				
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	8	6		
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч	10			Сахилгын болон захиргааны шийтгэл сүүлийн 2 жилд хүлээгээгүй
Гав- тугаар үшээ	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч				
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч				

		ийг			
		н			
		лах			
		анд			

түүн түшээ зэрэг дэвийг Улсын ийн тэргүүн түшээ зэрэг дэвийг Улсын дээд  
 Улсын Ерөнхийлөгч, бусад зэр Монгол Улсын Ерөнхийлөгч, бусад зэрэг  
 , нийслэлийн шүүхийн ерөнх, аймаг, нийслэлийн шүүхийн ерөнхий  
 Шүүхийн ерөнхий зөвлөл олгсноор Шүүхийн ерөнхий зөвлөл олгоно.  
 р томилсноос хойш 45 хоног шүүгчээр томилсноос хойш 45 хоногийн

дээсэн бол түүний зэрэг дэвийг шийтгэл хүдээсэн бол түүний зэрэг дэвийг нэг  
 г дэвийг нь бууруулсан шүүгчүү зэрэг дэвийг нь бууруулсан шүүгчид  
 асуудлыг сахилгын шийтгэл олгох асуудлыг сахилгын шийтгэлгүйд  
 заасны дагуу ердийн журм дүрэмд заасны дагуу ердийн журмаар

бусад тохиолдолд шүүгчийн э зааснаас бусад тохиолдолд шүүгчийн зэрэг

үндэслэл журмын дагуу а завсан үндэслэл журмын дагуу албан  
 буулсан бол шүүгчийн зэрэг н, огцруулсан бол шүүгчийн зэрэг дэв  
 доно.

г дэвийн нэмэгдэл, түүнийг  
 буулах журам

ийн зэрэг дэвийн нэмэгдэл, түүнийг  
 лгох, бууруулах журам

нэмэгдлийг түүний албан тушаагийн нэмэгдлийг түүний албан тушаалын  
 олгоно: э тооцож олгоно:

Гутгаар түшээ	Дөтгөөр түшээ	Талдуг түшээ	Дэд түшээ	Гутгаар түшээ	Дөтгөөр түшээ	Талдугаар түшээ
21	18	15	23	21	18	15

нэмэгдлийг сар бүр олгоно. ийн нэмэгдлийг сар бүр олгоно.  
 хүдээж зэрэг дэв нь буурсан шийтгэл хүдээж зэрэг дэв нь буурсан бол  
 ан зэрэг дэвээр олгоно. Шүүгч буурсан зэрэг дэвээр олгоно. Шүүхийн  
 гч сахилгын шийтгэл хүдээсэн (втэй шүүгч сахилгын шийтгэл хүдээсэн бол

сахилгын шийтгэлтэй байсан хугацаанд илгын шийтгэлтэй байсан х  
олгохгүй. олгохгүй.

13.Шүүгчийг хууль заасан үндэслэл, 13.Шүүгчийг хууль заасан  
тушаалаас нь чөлөөлсөн бол түүнд зэрэг дэвн  
тушаалаас нь чөлөөлсөн бол түүнд

14.Тэтгэвэрт гарсан шүүгч шүүгчийг 14.Тэтгэвэрт гарсан шүүгч  
тохиолдолд урьд олгосон зэрэг дэвийн нэмэгдэл  
тохиолдолд урьд олгосон зэрэг дэ

15.Шүүгчийг орлон ажиллаж байгаа т 15.Шүүгчийг орлон ажиллаж  
тавдугаар түшээ зэрэг дэвийн нэмэгдэл олго  
дугаар түшээ зэрэг дэвийн нэм

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУ ТОГТООЛ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУ ТОГТООЛ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 08

6 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 08

Ж.Б.  
Цэцгийн

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран Монгол Улсын Үндсэн хуулийн  
цэцгийн заалтыг үндэслэн Улсын Их Хурлаас цэцгийн заалтыг үндэслэн Улсын И

Монгол Улсын Их Хурлын санал бол Монгол Улсын Их Хурлын с  
Бямбажавыг Үндсэн хуулийн цэцгийн 6-бажавыг Үндсэн хуулийн  
томилсугай. томилсугай.

Дэд дарга

1 дарга

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУ ТОГТООЛ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУ ТОГТООЛ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 09

6 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 09

Үндсэн  
алба:

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь Монгол Улсын Их Хурлаас ТОГ  
1.Үндсэн хуулийн Цэцгийн гишүүнд сар 1.Үндсэн хуулийн Цэцгийн гиш  
онцгой нөхцөлийн нэмэгдлийг арван агай нөхцөлийн нэмэгдлийг  
тогтоосугай. тоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулж “Цалингийн хэмжээ тогтоох, төсөв, хөлс олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар тогтоолын 4 дэх заалтыг хүчингүй болгосугай.

Дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

Нийгмийн даатгалын хуулиудад нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулиудыг  
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.1996 оны 3 дугаар сард багтаан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/нийгмийн даатгалын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан дагаж мөрдөж байгаа заавар, журмыг уул хуулиудад нийцүүлэх;

2/нийгмийн даатгалын шимтгэл оногдуулах сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 1996 онд баримтлах дээд хэмжээг баталж мөрдүүлэх;

3/1995 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд даатгуулагчийн шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тогтоосон дээд хэмжээнээс дээгүүр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосон иргэний тэтгэврийг шинэчлэн тогтоох.

2.Энэ тогтоолын 1 дэх хэсгийн 3 дахь заалтын дагуу тэтгэврийг шинэчлэн тогтоохоо даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг уг даатгуулагчид буцаан олгосугай.

Дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1996 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Их Хурлын 1996 оны  
хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын 1996 оны хаврын чуулганаар дор дурасан асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай:

1.Энсийн хэлэлцүүлэгт оруулах хуулиуд:

1/Эрүүгийн хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;

2/Ургамал хамгааллын тухай хууль;

3/Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, хураах үйл ажиллагааны журмын тухай хууль;

4/Коррупцийн эсрэг тэмцэх тухай хууль;

5/Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын үндэс, Соёлын тухай хууль;

6/Монгол Улсын Үндэсний хөгжлийн үзэл баримтлал.

2.Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахтай холбогдсон асуудал:

1/Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг товлон зарлах тухай;

2/Сонгуулийн тойрог байгуулах, сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай.

3.Улсын Их Хуралд ажлаа хариуцдаг, тайлагнадаг этгээдийн гайлан.

4.Бусад асуудал.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1996 оны 2 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

**Ж. Олибайд Монгол Улсын хүний  
гавьяат эмч цол олгох тухай**

Эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж гэмтэл, согогийг мэргэжил, ур чадварын өндөр түвшинд эмчлэн, өвчтөнд үзүүлэх тусламжийн чанарыг сайжруулах, гэмтсэн эд эрхтний үйл ажиллагааг нөхөн сэргээх мэс заслын аргуудыг чадварлаг эзэмшин өөрийн орны эмчилгээний практикт амжилттай нэвтрүүлж олон хүний хөдөлмөрийн чадварыг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Гэмтэл согогийн клиникийн төв эмнэлгийн зөвлөх их эмч Жүгдэрийн Олибайд Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1996 оны 2 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

1. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасныг үндэслэн "Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуудах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ зарлигийг 1996 оны 2 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

Ерөнхийлөгчийн 1996 оны 19  
дүгээр зарлигийн хавсралт

## УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ИРГЭДИЙГ ОРОЛЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасны дагуу Монгол Улсын иргэн сайн дурын үндсэн дээр улсын хил хамгаалалтад оролцож болно.

2. Аймаг, сум (хороо)-ын Засаг дарга Улсын хил хамгаалалтад сайн дурын үндсэн дээр оролцох иргэдийг ажил, үйлдвэртэл, нутаг дэвсгэрийн байрлалаар нь байнгын болон түр хугацаагаар улсын хил хамгаалалтад туслах хүч (цаашид энэ журамд "туслах хүчин" гэнэ) болгон зохион байгуулж улсын хил хамгаалалтад оролцуулна.

3. Туслах хүчнийг хил орчмын аймаг, сум, багийн төв, хилийн боомт, хилийн сумангийн хэсэг, суурин газар, төмөр замын өртөө, зөрлөг болон шаардлагатай бусад газарт улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн аймгийн засаг даргын захирамжаар байгуулна.

4. Туслах хүчний зорилт нь улсын хилийн бүс, зурваст улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад хилчдэд туслахад оршино.

5. Улсын хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, 18 нас хүрэн Монгол Улсын иргэн улсын хил хамгаалалтад сайн дурын үндсэн дээр оролцох хүсэлтээ сум (хороо)-ынхаа Засаг даргад бичгээр гаргана. Уг хүсэлтийг хилийн тухайн хорооны саналыг үндэслэн сум (хороо)-ын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэртэнэ. Улсын хил хамгаалалтад туслах хүчний бүрэлдэхүүнд орсон иргэнийг туслах хүчний гишүүн гэнэ. Туслах хүчний гишүүн үнэмлэхтэй байна. Үнэмлэхийн загварыг хилийн цэргийг удирдах төрийн захиргааны байгууллага батална.

6. Туслах хүчний үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль, хууль тогтоомжийн холбогдох бусад акт, энэ журмыг удирдлага болгоно.

7. Туслах хүчний зэвсэглэл, холбоог улсын хил хамгаалах байгууллага харьцана.

## Хоёр. ТУСЛАХ ХҮЧНИЙ УДИРДАГА

8. Туслах хүчний удирдлагыг Монгол Улсын Хилийн тухай хуульд заасанчлан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, түүний дэргэдэх орон тооны бус зөвлөл, улсын хил хамгаалах байгууллага тус тусын бүрэн эрхийн хэмжээнд хэрэгжүүлнэ.

9. Хилийн аймаг, сум (хороо)-ын Засаг даргын дэргэд Хил хамгаалалтад туслах орон тооны бус зөвлөл (цаашид энэ журамд "Зөвлөл" гэнэ) ажиллана.

10. Хилийн аймаг, сум (хороо)-ын Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн зорилт нь Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Засаг даргад туслах явдал мөн.

11. Аймгийн зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга, орлогч дарга нь хилийн хорооны захирагч, нарийн бичгийн дарга нь Засаг даргын тамгын газрын дарга, гишүүд нь аймгийн цагдаагийн хэлтэс (газрын)-ийн дарга, Тамгын газрын санхүүгийн болон нийгэм эдийн засгийн асуудал хариуцсан нэгжийн дарга, аймгийн тагнуулын албаны дарга, холбооны газрын дарга, эрүүл мэндийн газрын дарга, мал эмнэлгийн албаны дарга, хилийн сумдын Засаг дарга байна. Аймгийн Засаг дарга захирамж гаргаж бусад хүнийг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж болно.

12. Сумын зөвлөлийн дарга нь сумын Засаг дарга, орлогч дарга нь хилийн хорооны штабын дарга, нарийн бичгийн дарга нь сумын Засаг даргын тамгын газрын дарга, гишүүд нь сумын санхүүгийн тасгийн дарга, цагдаагийн хэлтэс (тасаг, хэсэг)-ийн дарга, холбооны дарга, тагнуулын ажилтан, хүн, мал эмнэлгийн албаны дарга, багийн засаг дарга байна. Сумын Засаг дарга захирамж гаргаж бусад хүнийг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж болно.

13. Хилийн цагийн байдал, хил хамгаалалтын онцлогтой уялдуулан сумын Засаг даргын шийдвэрээр туслах хүчний багийн зөвлөлийг байгуулж болно. Багийн зөвлөлийн дарга нь багийн Засаг дарга байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнээ хилийн хороо, сумангийн удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр тогтооно.

14. Зөвлөлийн ажиллах журмыг тухайн Засаг дарга тогтооно.

15. Аймгийн зөвлөл нь:

1/ нутаг дэвсгэртээ байгаа улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн хангалт үйлчилгээнд нь туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна;

2/ хилийн тухай хууль тогтоомжийг иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хэрхэн сахин биелүүлд байгааг хянан шалгаж шаардлагатай арга хэмжээ авна;



3/ туслах хүчнийг улсын хил хамгаалалтад оролцуулах ажлыг улсын хил хамгаалах байгууллагатай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулна;

4/ хил орчмын дэглэмийн биелэлтэд Засаг даргаас тавих хяналтыг хэрэгжүүлнэ;

5/ улсын хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардлыг хилийн сумын төсөвт тусгуулах арга хэмжээ авч хэрэгжилтэд нь хяналт тавина;

6/ хилийн цагийн байдлын мэдээллийг орон нутгийн байгууллага, иргэдэд хүргэх арга хэмжээ авна;

7/ улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахтай холбогдсон асуудлаар санал боловсруулж холбогдох байгууллагад оруулна;

8/ улсын хил хамгаалалтад идэвхтэй оролцсон туслах хүчний гишүүн, иргэнийг урамшуулж, түүнд зохих хөнгөлөлт үзүүлэх асуудлыг холбогдох байгууллагад оруулна.

16. Сумын зөвлөл нь:

1/ хилийн сумангийн үйл ажиллагаанд туслах ажлыг зохион байгуулна;

2/ улсын хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардлыг сумын төсөвт тусган зохих журмын дагуу зарцуулна;

3/ улсын хил орчмын дэглэмийн биелэлтийг хилийн хороотой хамтран шалгана;

4/ хилийн бүс, зурваст ажил, үйлдвэртэл эрхэлж байгаа туслах хүчний гишүүдийг оршин суугаа газраар нь хил хамгаалалтад оролцуулах ажлыг зохион байгуулна;

5/ иргэд, байгууллага хилийн бүс, зурваст тогтоосон журмын дагуу ажил, үйлдвэртэл эрхэлж байгаа эсэхэд хяналт тавина;

6/ хилийн хороо, сумантай тохиролцсоны дагуу туслах хүчний гишүүдийн сургалт цугларалтыг зохион байгуулна;

7/ хилийн цагийн байдлын мэдээллийг хил хамгаалах байгууллагаас авч холбогдох мэдээллийг орон нутгийн байгууллага, иргэдэд хүргэх, хил орчмын оршин суугчдын сонор сэрэмж, хариуцлагыг зохих түвшинд байлгах арга хэмжээ авна;

8/ улсын хил хамгаалалтад оролцох хүсэлт гаргасан хүнийг сумын хил хамгаалах туслах хүчний бүрэлдэхүүнд оруулах эсэх асуудлыг хилийн тухайн хорооны саналыг үндэслэн зөвлөлийн хурлаар хэлэлцэж зохих шийдвэр гаргана;

9/ хилийн эрэл, цагийн байдлын хүндэрсэн үед туслах хүчний гишүүдийг ажил, үйлдвэртэлээс нь чөлөөлж, хилийн манаанд үүрэг гүйцэтгүүлэх, хилийн харуул манаа, эргүүл, бүлгүүдийг зохион байгуулж ажиллуулах арга хэмжээ авна;

10/ улсын хилийн болон хил орчмын дэглэмийг санаатайгаар буюу давтан зөрчсөн Монгол Улсын иргэнийг хуулийн байгууллагад шилжүүлэх саналыг холбогдох байгууллагад оруулна;

11/ хил хамгаалалтад идэвхтэй оролцсон туслах хүчний гишүүн, иргэнийг сайшаан урамшуулах, зохих хөнгөлөлт үзүүлэх асуудлыг холбогдох байгууллагад оруулна;

12/ хилийн бүс, зурваст нутаглах айл өрхийн талаар саналаа хил хамгаалах байгууллагад оруулна.

17. Багийн зөвлөл нь:

1/ туслах хүчний гишүүдийг улсын хил хамгаалалтад график төлөвлөгөөний дагуу оролцуулах ажлыг зохион байгуулна;

2/ туслах хүчний гишүүдийн үүрэг гүйцэтгэлийг хилийн сумантай хамтран шалгана;

3/ иргэд, байгууллага хилийн бүс, зурваст тогтоосон журмын дагуу ажил, үйлдвэрлэл эрхэлж байгаа эсэхэд хяналт тавина;

4/ улсын хил хамгаалалтад идэвхтэй оролцсон туслах хүчний гишүүн, иргэнийг сайшаан урамшуулах саналыг холбогдох байгууллагад оруулна.

18. Аймгийн зөвлөл нь туслах хүчнийг хил хамгаалалтад оролцуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг дулааны ба хүйтний улирлаар боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулна.

Туслах хүчний гишүүдийн байршил, хамгаалалтад оролцох боломжийг тусгасан тайлбар зураг, бүдүүвчийг үйлдсэн байна.

Сум, багийн зөвлөл нь ажлын төлөвлөгөөгөө сар, улирлаар гаргана.

Туслах хүчний гишүүд нь хил хамгаалалтад оролцох график төлөвлөгөөтэй байна.

Аймгийн зөвлөл нь сум, багийн зөвлөлийн ажлыг жилд 2-оо доошгүй удаа шалган зааварчилга өгч ажиллана.

19. Хилийн цэргийг удирдах газар нь:

1/ улсын хил хамгаалалтад иргэдийг татан оролцуулах үндсэн бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авна;

2/ улсын хил хамгаалахад туслах хүчний гишүүдийн нэгдсэн цугларалтыг зохион байгуулна;

3/ туслах хүчний зөвлөл, гишүүдийн хил хамгаалалтад оролцох төлөвлөгөө, холбогдох бусад баримт бичгийг боловсруулан гаргаа хүргүүлнэ;

4/ улсын хил хамгаалалтад идэвхтэй оролцож онцгой гавьяа байгуулсан туслах хүчний гишүүн, иргэдийг төрийн дээд шагналаар шагнуулахаар тодорхойлно.

20. Хилийн хороо нь:

1/ хил хамгаалалтад оролцох хүсэлт гаргасан иргэнийг судалж туслах хүчний бүрэлдэхүүнд оруулах эсэх талаарх саналаа холбогдох зөвлөлд гаргана;

2/ улсын хил хамгаалах шийдвэртээ туслах хүчнийг ашиглах талаар тодорхой тусгана;

3/ улсын хил хамгаалалтад оролцож идэвх зүтгэл гаргасан туслах хүчний гишүүд ажилласан цаг хугацааг харгалзан зохих хууль тогтоомжийн дагуу мөнгөн урамшуулал олгоно;

4/ туслах хүчнийг хил хамгаалалтад оролцуулах боломжийг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлтэй хамтран боловсруулна;

5/ туслах хүчний зөвлөлийн удирдлагыг хилийн цагийн байдлын шаардлагатай мэдээллээр хангана;

6/ аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлтэй хамтран туслах хүчний гишүүдийн цугларалт, сургалтыг зохион байгуулна;

7/ туслах хүчний үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлнэ;

8/ хил орчмын нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, иргэдэд улсын хил хамгаалалтын улс төр, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулж, хилийн тухай хууль тогтоомж, эрх зүйн актуудыг сурталчилна;

9/ хил хамгаалахад идэвхтэй оролцсон, амжилт гаргасан туслах хүчний гишүүдийг шагнаж урамшуулна;

10/ туслах хүчний гишүүдийн хөтлөх баримт бичиг, нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө, хамгаалалтын бүдүүвч, тайлбар зургийг Засаг даргын дэргэдэх зөвлөлд өгнө.

#### 21. Хилийн суман нь:

1/ хариуцсан хэсэгтээ байнга байрлаж байгаа туслах хүчний гишүүдэд хилийн тодорхой хэсгийг хариуцуулан өгч, үүрэг гүйцэтгүүлэх талаар хоногийн хил хамгаалах шийдвэртээ тусгана;

2/ туслах хүчний гишүүдийн ердийн болон хүч нэмэгдүүлсэн хамгаалалт, хилийн эрлийн үед үүрэг гүйцэтгэх график төлөвлөгөө гаргана;

3/ туслах хүчний гишүүдийн үүрэг гүйцэтгэлийг шалгаж дүнг хилийн албаны дэвтэрт тэмдэглэнэ;

4/ хил хамгаалалтад оролцож байгаа туслах хүчний гишүүдийн цугларалтыг зохион байгуулж, тэдний үүрэг гүйцэтгэлтийг дүгнэн дүнг мэдээлж байна;

5/ хил хамгаалалтад идэвхтэй оролцсон туслах хүчний гишүүдэд шагнал, мөнгөн урамшуулал олгох талаар тодорхойлолт гаргаж холбогдох байгууллагад оруулна.

## Гурав. ТУСЛАХ ХҮЧНИЙ ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ, ЭРХ

22. Туслах хүчний гишүүн дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

1/ улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн буюу зөрчихийг завдсан этгээдүүдийг эрэн сурвалжлах ажиллагаанд оролцох;

2/ хилийн бүс, зурвас, боомтод мөрдөх журмын биелэлтийг сахиулах, өөрөө зөрчихгүй байх;

3/ улсын хил зөрчсөн, зөрчихөөр бэлтгэгдэж байгаа тухай мэдээллийг туслах хүчний зөвлөл болон хил хамгаалах байгууллагад нэн даруй мэдээлэх;

4/ тогтоосон журмын дагуу хилийн манааны үүрэг гүйцэтгэх;

5/ удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

6/ хилийн цагийн байдлын өөрчлөлтийн үед ажиллахад бэлэн байх, "Цугларалт" дохио өгөхөд түргэн хугацаанд цугларах;

7/ хил орчмын нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, ан агнуурын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх;

8/ хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа үед туслах хүчний гишүүний үнэмлэхээ биедээ байнга авч явах.

23. Туслах хүчний гишүүн хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа үедээ Монгол Улсын Хилийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан эрх эдэлнэ. Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж буй иргэдийн эрх зүйн баталгаа нь Монгол Улсын Хилийн тухай хуульд заасны дагуу хангагдана.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1996 оны 2 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар  
хот

М. Албанчид Монгол Улсын хүний  
гавьяат эмч нол олгох тухай

Хэдөө орон нутагт хүүхэд нялхсын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх ажилд олон жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн жилүүдэд нялхсын эндэгэлийг тогтвортой бууруулж, хүүхдийн эсэн мэнд бойжих нөхцөлийг хангах, хамгаалах, хөгжүүлэх тухай дэлхий дахины тунхаглалын үзэл санааг хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Ховд аймгийн Эрүүл мэндийн нэгдсэн төвийн хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн их

эмч Мэргэний Албанчид Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1996 оны 2 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

С. Дэчинпилд Монгол Улсын гавьяат  
агрономич цол олгох тухай

Газар тариалангийн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж манай улсад чацарганы аж ахуйг хөгжүүлэх, хүнсний ногооны эрдэм, шинжилгээ, туршилтаа ажлыг үйлдвэрлэлтэй хослон явуулж гадаадаас өндөр үнээр авдаг байсан шар луувангийн үрийн хэрэгцээг бүрэн хангаж, байцаа, манжингийн үр үржүүлэн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улаангом дахь газар тариалангийн эрдэм шинжилгээний станцын эрдэм шинжилгээний ажилтан Сурангаагийн Дэчинпилд Монгол Улсын гавьяат агрономич цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1996 оны 2 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

Д. Батчулууныг Хөдөлмөрийн гавьяаны  
улаан тугийн одонгоор  
шагвах тухай

Үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж гар хивс нэхэх арга, технологийг чадамгай эзэмшин 30 гаруй нэр төрлийн олон арван хивсийг мэргэжлийн өндөр төвшинд нэхэж, гар хивсний

урлалыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн "Монгол гар хивс" компанийн хивсчин Доржийн Батчулууныг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1996 оны 2 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар  
хот

**Ж. Лхагвыг Хөдөлмөрийн гавьяаны  
улаан тугийн одонгоор шагнах  
тухай**

Хэвтэл мэдээллийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж уншигчдын талархал хүлээсэн олон арван өгүүдэл, ном зохиол туурвихын зэрэгцээ гадаадын нэрт зохиолчдын бүтээлээс орчуулан нийтийн хүртээл болгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Үнэн" сонины утга зохиолын ажилтан Жагдалын Лхагвыг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1996 оны 2 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Прокурорын дүрэмт хувцасны загварыг 1 дүгээр хавсралт, Прокурорын зэрэг дэвийн алгах тэмдгийн загварыг 2 дугаар хавсралт, Прокурорын дүрэмт хувцсыг хэрэглэх журмыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Прокурорын дулааны улиралд өмсөх дүрэмт хувцсыг 1996 оноос, хүйтний улиралд өмсөх дүрэмт хувцсыг 1997 оноос эхлэн хэрэглэхээр тус тус тогтоосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1996 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 26 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт

### ПРОКУРОРЫН ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ЗАГВАР

1. Прокурорын дүрэмт хувцас нь Прокурорын байгууллагын нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг тусгаж, төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан тушаалтны нэр төр, сүр хүнийг илэрхийлнэ.

2. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан прокурорын дүрэмт хувцас нь дараахь загвартай байна.

Хар хөх өнгийн саравчтай малгай. Малгайн саравчны голлох дээд талд шар өнгийн бадам цэцэг дээр суурилсан Прокурорын байгууллагын бэлгэдлийг байрлуулсан байна. Малгайны хүрээ нь цэнхэр өнгөтэй байна.

Хар хөх өнгийн дугуй малгай. Малгайн голлох хэсэгт шар өнгийн бадам цэцэг дээр суурилсан Прокурорын байгууллагын бэлгэдэл байна. Энэ малгайд зөвхөн эмэгтэй прокурор өмсөж хэрэглэнэ.

Хар хөх өнгийн задгай энгэртэй китель. Кителийн ханцуй нь цэнхэр өнгийн эмжээртэй, эрэгтэй прокурорын кителийн энгэрт соёмбо бүхий зургаан ширхэг, эмэгтэй прокурорын кителийн энгэрт дөрвөн ширхэг шар өнгийн том товч, хоёр ханцуйнд мөн соёмбо бүхий тус бүр хоёр жижиг шар товч байна. Харин Улсын Ерөнхий Прокурор, түүний орлогч нарын кителийн захны үзүүр нь шар өнгийн битүү сүлжмэл угалзан хээ бүхий саан эмжээртэй, кителийн товчнууд нь төрийн сүлдтэй байна.

Хар хөх өнгийн урт өмд. Улсын Ерөнхий Прокурор, түүний орлогч нарын урт өмд нь хоёр талдаа цэнхэр өнгийн гурвалсан эмжээр /кант/-тэй байх бөгөөд хоёр захын эмжээр нь тус бүр 18-20 мм, голын эмжээр нь 2 мм өргөнтэй, эмжээр хоорондын зай 5 мм байна. Харин бусад прокурорын урт өмд нь хоёр талдаа 2 мм-ийн өргөнтэй цэнхэр өнгийн дан эмжээртэй /юбка нь ар талдаа битүү оноотой/ байна.

Хар хөх өнгийн задгай энгэртэй дотортой цув. Цувны энгэрт соёмбо бүхий зургаан ширхэг шар өнгийн том товч, хоёр ханцуйд нь соёмбо бүхий тус бүр хоёр ширхэг жижиг товч байна. Улсын Ерөнхий Прокурор, түүний орлогч нарын цувны товч нь төрийн сүлдтэй байна.

Өвлийн малгай. Малгайн голлох хэсэгт шар өнгийн бадам цэцэг дээр суурилсан Прокурорын байгууллагын бэлгэдэл байна. Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөх, хууль цаазын итгэмжит зөвлөх зэрэг дэвтэй прокурор каракуль малгай, бусад прокурор цегейк малгай тус тус өмсөнө.

Өвлийн пальто. Каракуль /цегейк/ захтай, энгэртээ соёмбо бүхий зургаан ширхэг шар өнгийн том товч, хоёр ханцуйд нь соёмбо бүхий тус бүр хоёр ширхэг жижиг товч байна. Улсын Ерөнхий Прокурор, түүний орлогч нарын пальтоны товч нь төрийн сүлдтэй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1996 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 26 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт

## ПРОКУРОРЫН ЗЭРЭГ ДЭВИЙН ЯЛГАХ ТЭМДГИЙН ЗАГВАР

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 6-д зааснаар зэрэг дэв бүхий прокурор дүрэмт хувцандаа зэрэг дэвийг тусгасан ялгах тэмдэг-мөрдөсийг хэрэглэнэ.

2. Мөрдөсний голчийн урт нь 11-18 см, өргөн нь 5-6 см хэмжээтэй байна. Мөрдөс дээр зэрэг дэвийн ялгааг тусгасан таван хошуу /соёмбо/-г байрлуулна.

3. Мөрдсийг кительд оёж тогтооно.

4. Мөрдөсний төрөл:

а/ Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөхийн мөрдөс нь битүү сүлжмэл, алхан хээ бүхий саан эмжээртэй, аллаг шар өнгийн эдээр хийсэн байна;

б/ Хууль цаазын итгэмжит зөвлөх, хууль цаазын ахлах зөвлөх, хууль цаазын зөвлөхийн мөрдөс нь цэнхэр өнгийн торгомсог эдээр хийсэн байна;

5. Мөрдөс дээр прокурорын зэрэг дэвийн ялгааг тусгасан таван хошуу /соёмбо/-г дараахь байдлаар байрлуулна:



Зэрэг дэв	Мөрдлөг дээрх таван хошуу, соёмбоны хэмжээ, тоо ширхэг	Мөрдсөний тэгш өнцгөөс эхлэн тэмдгийн төв хүртэлх зай /мм/	Тэмдэг хоорондын зай /мм/ таван хошууны голоос
Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх	30 мм-ийн нэг таван хошуу, 30 мм-ийн өргөнтэй соёмбо	30-35	30
Төрийн хууль цаазын шадар зөвлөх	25 мм-ийн нэг таван хошуу	55-65	
Хууль цаазын итгэмжит зөвлөх	20 мм-ийн гурван таван хошуу	30-35	30
Хууль цаазын ахлах зөвлөх	20 мм-ийн хоёр таван хошуу	35-45	30
Хууль цаазын зөвлөх	20 мм-ийн нэг таван хошуу	50-65	

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1996 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 26 дугаар зарлигийн 3 дугаар хавсралт

### ПРОКУРОРЫН ДҮРЭМТ ХУВЦСЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 утгар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зэрэг дэвтэй прокурор Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан загварын дүрэмт увцсыг өмсөнө.

2. Прокурор албан үүргээ гүйцэтгэж байгаа үедээ дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэнэ.

3. Прокурорын дүрэмт хувцасны эдэлгээний хутацааг Монгол Улсын Ерөнхий Прокурор тогтооно.

4. Прокурор дүрэмт хувцсаа цэвэр нямбай, ариг гэмтэй өмсөж үрэгтэй.

5. Прокурор албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд прокурорын дүрэмт хувцас хэрэглэхгүй.

Албан тушаалаасаа чөлөөлөгдсөн прокурорт дүрэмт хувцсыг нь хадгалуулж болох бөгөөд уг дүрэмт хувцсыг баяр ёслол болон прокурорын байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцоходоо хэрэглэж болно. Харин сахилгын шийтгэл хүлээж, эсхүл гэмт хэрэг үйлдэж ажлаас халагдсан прокуророос дүрэмт хувцсыг нь буцааж авна.

6. Прокурор дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно:

а/ дүрэмт хувцасны өнгө, загвар, хэлбэрийг өөрчлөх;

б/ дүрэмт хувцсыг тухайн зорнулалтын энгийн болон өөр бусад хувцастай хослуулж өмсөх;

в/ дүрэмт хувцсыг барьцаалах, худалдах, бусдад хэрэглүүлэх;

г/ дүрэмт хувцсанд зөвшөөрөгдөөгүй ялгах тэмдэг хэрэглэх.

7. Прокурор дүрэмт хувцсандаа хүндэтгэлтэй хандана.

8. Прокурорын дүрэмт хувцсыг хэрэглэх журмыг зөрчсөн бол прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж үзнэ. Харин прокурорын дүрэмт хувцсыг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд түүний эдэлгээний элэгдлийг хассан үнийг төлүүлнэ.

9. Прокурорын дүрэмт хувцсыг хэрэглэх журмын биелэлтэд аймаг, нийслэл, тээврийн прокурор болон Улсын Ерөнхий Прокурорын Хэрэг эрхлэх газар хяналт тавина.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 9 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар  
хот

**Ерөнхий боловсролын сургуулийн дотуур  
байрны сурагчдын хоол хүнс, ахуйн  
хангамжийн талаар авах зарим  
арга хэмжээний тухай**

Боловсролын тухай Монгол Улсын хуулийн 36 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 1,2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны сурагчдын хоол хүнс, зайлшгүй шаардлагатай ариун цэврийн барааны зардлыг дотуур байранд суух сурагчдын тоо, нэг суралцагчид ногдох зардлын нормативыг үндэслэн тооцож, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх тухайн жилийн үндсэн чиглэл, төсөвт тусгаж байхыг Үндэсний хөгжлийн газар /Ч. УЛААН/, Шинжлэх ухаан боловсролын яам /С. ТӨМӨР-ОЧИР/, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Дотуур байранд сууж байгаа сурагчийн дор дурдсан зардлыг Боловсролын тухай Монгол Улсын хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан эх үүсвэрт багтаан орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай:

а/ бүтэн өнчин хүүхдийн хоол хүнс, хувцас, сурах бичиг, хичээлийн бусад хэрэглэл, зайлшгүй шаардлагатай ариун цэврийн барааны зардал;

б/ амьдрал ядуу, нэн бага орлоготой өрхийн хүүхдийн хоол хүнсний болон сурах бичиг, хичээлийн бусад хэрэглэлийн зардал;

в/ дотуур байрны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай эрчим хүч, дулаан, тохижилт, үйлчилгээний болон бусад холбогдох зардал;

г/ дотуур байрны дотоод тавилга, ор дэрний хэрэглэл авах, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагатай үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардал;

3. Сум, дүүргийн Засаг дарга нарт даалгах нь:

а/ ерөнхий боловсролын бага, дунд сургуулийн дотуур байрны сурагчдын хоол хүнсний зүйлийн бүрэлдэхүүнд орох хүнсний бү-

тээгдэхүүний тоо хэмжээг эрүүл мэндийн болон боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүүхдийн физиологийн хэрэгцээг хангахад шаардагдах хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, илчлэгийн хэмжээ, тухайн орон нутгийн онцлог, дотуур байранд суух хугацаатай уялдуулан тогтоож, холбогдох зардлыг Боловсролын тухай Монгол Улсын хуулийн 36 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 2-т заасны дагуу эцэг, эх, асран хамгаалагчаас гаргуулан авах, өрхийн орлого, амьжиргааны түвшинг нь харгалзан зарим эцэг, эх, асран хамгаалагчийг төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зардлын асуудлыг 1995/1996 оны хичээлийн жилээс эхлэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтайгаа зөвшилцөн шийдвэртэй байсугай;

б/ эцэг, эх, асран хамгаалагчаас сургуулийн дотуур байранд сууж байгаа хүүхдийнхээ хоол хүнсэнд зориулан сургуульд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний гэрээ хэлцэл байгуулах ажлыг хариуцан зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласугай;

в/ ерөнхий боловсролын сургуулийг туслах аж ахуйтай болгоход дэмжлэг үзүүлж, дотуур байрны сурагчдыг мах, сүү, цагаан идээ, төмс, хүнсний ногоогоор хангах ажлыг сайжруулах арга хэмжээг энэ оноос эхлэн лэс дараатайгаар авч хэрэгжүүлсүгэй;

г/ сурагчдын дотуур байрны тохижилт, үйлчилгээ, хоол хүнсний хангалтыг сайжруулахад нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас дэмжин туслах хөдөлгөөн өрнүүлж ажиллах арга хэмжээ авсугай;

д/ дотуур байранд сууж байгаа хүүхдийнхээ хоол хүнсний бүтээгдэхүүнийг хугацаанд нь нийлүүлээгүй, эсвэл нийлүүлэхээс зайлсхийсэн эцэг, эх, асран хамгаалагчаар уг үүргийг нөхөн гүйцэтгүүлэх арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч байсугай;

е/ дотуур байрны халаалтад шаардагдах түлээ түлш бэлтгэх зэрэгт эцэг, эх, асран хамгаалагчийн туслалцаа авах ажлыг бүх талаар дэмжиж, туслах арга хэмжээ авч байсугай.

4. "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохижилт үйлчилгээний болон дотуур байрны сурагчдыг хоол хүнсээр хангах нийтлэг журам"-ыг энэ оны 10 дугаар сард багтаан баталж 1995/1996 оны хичээлийн жилээс эхлэн мөрдүүлэх арга хэмжээ авахыг Шинжлэх ухаан, боловсролын яам /С. ТӨМӨР-ОЧИР/, Сангийн яам /Э. БЯАМБАЖАВ/-д даалгасугай.

5. Байгууллагынхаа ажилчин, ажилчдын дотуур байранд суудаг хүүхдийн хоол, хүнс байрны зардлыг санхүүжүүлэхэд зохих дэмжлэг туслалцаа үзүүлж байхыг мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэр-

лэл, үйлчилгээ эрхэлдэг нөхөрлөл, компани, хоршооны эрх баригчдад зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Шинжлэх ухаан, боловсролын сайд  
Савгийн сайд

П. ЖАСРАЙ  
С. ТӨМӨР-ОЧИР  
Э. БЯМБАЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 10 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар  
хот

Эрчим хүч, геологи, уул уурхайн улсын  
хяналтын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрчим хүч, геологи, уул уурхайн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрмүүд батлах тухай" Засгийн газрын 1990 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 182 дугаар тогтоолын 3, 4 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Эрчим хүч, геологи, уул уурхайн сайд

П. ЖАСРАЙ  
Б. ЖИГЖИД

Засгийн газрын 1995 оны 190  
дүгээр тогтоолын хавсралт

## ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эрчим хүч, геологи, уул уурхайн улсын хяналт (энэ дүрэмд улсын хяналт гэх)-ын зорилт нь тус улсын нутаг дэвсгэр дээр эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэх, геологийн судалгаа хийх, ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд болон эрчим хүч, геологи, уул уурхайн тонег төхөөрөмж, зуух даралтат сав, шугам хоолой, шингэрүүлсэн шатдаг хий, үйлдвэрийн зориулалттай тэсрэх материал, тэсэлгээний

ажлын техник ашиглалт, аюулгүй ажиллагааны байдалд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр төрийн захиргааны хяналт явуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын мөрдөлтийг хангуулахад оршино.

2. Улсын хяналтыг эрчим хүч, геологи, уул уурхайн Улсын хяналтын алба (цаашид "хяналтын алба" гэх), аймаг нийслэлийн эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

3. Хяналтын албаны дарга нь эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын ерөнхий байцаагч байна. Эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын ерөнхий байцаагчийг эрчим хүч, геологи уул уурхайн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4. Эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор эрчим хүч, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө.

Аймаг, нийслэлд ажиллах эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд байцаагчийн эрхийг Эрчим хүч, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд олгоно.

5. Ажил төрлийн онцлог байдлаас шалтгаалан зарим яам, тусгай газар, байгууллагад эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч ажиллуулж болно. Яам, газар, байгууллагад ажиллах эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчийг сайд, дарга нар нь томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр байцаагчийн эрхийг нь Эрчим хүч, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд олгоно.

6. Эрчим хүч, геологи, уул уурхайн тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдож хүний амь нас хохироосон, хүний бие махбодид гэмтэл учруулсан, хүнд болон бүлэг осол, түүнчлэн техникийн ноцтой аваарь гарсан тохиолдолд байгууллага, аж ахуйн нэгжийн захиргаа нь энэ тухай хяналтын албанд яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

7. Эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчид нь эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын асуудлаар мэргэшсэн байна.

8. Хяналтын алба, эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

9. Эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын ерөнхий болон ахлах байцаагч, улсын байцаагчид (энэ дүрэмд байцаагч гэх)-

нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, шийдвэрийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### Хоёр. Эрчим хүч, геологи, уул уурхайн улсын хяналтын чиглэл

10. Улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ дараахь хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтэд хяналт тавьж гүйцэтгэлийг хангуулна:

-Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарт мөрдөж буй техник ашиглалт, аюулгүй ажиллагааны болон бусад дүрэм, журам;

-ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, нөөцийн балансад өөрчлөлт оруулах, геологи, маркшейдерийн ажил гүйцэтгэх заавар, журам;

-ашигт малтмалын орд бүхий талбайд барилга, байгууламж барих, ашигт малтмал олборлодог үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгах, нөөцөд үлдэх журам;

-үйлдвэртэлийн зориулалттай тэсрэх бодис үйлдвэртэх, тээвэртэх, хэрэглэхэд тавих шаардлага, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм, журам;

-0,07 Мпа-аас дээш даралттай уурын зуух, даралтат сав, 115 С-ээс дээш хэмтэй усан халаалтын зуух болон уур, усны шугам, дулааны цахилгаан станц болон нэгж агрегат нь 125 кВт-аас дээш хүчин чадалтай дизелийн цахилгаан станц, 0,4 кВ-аас дээш хүчдэлтэй цахилгаан шугам сүлжээг аюулгүй ашиглах дүрэм, журам;

-шингэрүүлсэн шатдаг хийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам;

-цахилгаан, дулааны эрчим хүчний хангагч, хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагууд эрчим хүчийг зүй зохистой, хэмнэлттэй хэрэглэх талаар тогтоосон дүрэм, журам;

б/ геологийн судалгааны улсын сангийн бүрдүүтэлт, ашиглалт, хамгаалалтын байдал;

в/ газрын хэвлийг ашиглах явцад болон ашигласны дараа гэрч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хүрээлэн байгаа орчныг хамгаалах арга хэмжээний биелэлт;

г/ ашигт малтмалын хаягдал, бохирдолтыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй, ордын баялаг хэсгийг сорчлон олборлуулахгүй байх шаардлагын биелэлт;

д/ улсын хяналтад хамаарах байгууллага, аж ахуйн нэгж, тоног төхөөрөмжтэй холбогдож гарсан хүний амь үрэгдүүлсэн, хүнд болон бүдэг осол, үйлдвэртэлийн ноцтой аварга, саатлын шалтгааныг тус-

гайлан судлан тогтоох, осол аваарнаас урьдчилан сэргийлэх ажлын явц, байдал;

е/ улсын хяналтад хамаарах дулаан, цахилгааны тоног төхөөрөмж, шугам сүлжээ, зуух, даралтат сав хариуцан ажилладаг, мөн түүнчлэн үйлдвэрлэлийн тэсэлгээний ажил явуулдаг инженер-техникийн ажилтан, ажилчдын техникийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн мэдлэг, сургалтын байдал;

ж/ шинээр барих, өргөтгөх, шинэчлэх үйлдвэрийн зураг төсөлд болон зохион бүтээж байгаа технологи, тоног төхөөрөмж, хэрэгсэл, үйлдвэрийн бүтээгдэхүүний эрчим хүчний зарцуулалтын түвшингийн байдлын шинжилгээ судалгаа (экспертиз), дүгнэлт;

з/ хэрэглэгчийн цахилгаан тоноглол, хэрэгсэл нь эрчим хүч хэмнэх нөхцөлийг бүрдүүлж байгаа эсэх;

и/ эрчим хүчний үйлдвэрлэлийн технологийн зориулалтаар ашиглаж байгаа түлш, мөн түүнчлэн эрчим хүчний хэрэглээний норм, чанарын үзүүлэлт зохих хэмжээндээ байгаа эсэх.

11. Аймаг, нийслэлд ажиллаж байгаа эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг Эрчим хүч, геологи, уул уурхайн улсын хяналтын алба хариуцан хэрэгжүүлнэ.

#### **Гурав. Эрчим хүч, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх**

12. Байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ энэ дүрмийн 10 дугаар зүйлд заасан чиглэлийн дагуу улсын хяналтыг хэрэгжүүлэх;

б/ ашигт малтмалын ордыг ашиглалтад шилжүүлэх, уурхайн эдэлбэр, геологийн судалгаа болон бусад зориулалтаар газрын хэвлий олгох асуудлыг хянаж, зөвшөөрөл олгох;

в/ орд газрыг ашиглах зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийг хянах;

г/ тэсрэх бодис үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, тэсэлгээний ажил хийх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хянаж зөвшөөрөл олгох;

д/ уур, усан халаалтын зуух, даралтат сав, шугам хоолойг улсын бүртгэлд авах, техникийн магадлал хийх, ашиглах зөвшөөрөл олгох;

е/ техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, эрчим хүчний борлуулалт, хэмнэлт, геологийн судалгаа, ашигт малтмалын олборлолт,



түүний нөөцийн хамгаалалттай холбоотой дүрэм, журмын биелэлтийн байдалд хяналт тавих.

13. Байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/ хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусгаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн аюул осол гарч болох, эрчим хүч хэрэглэх, ашиглах, геологийн судалгаа явуулах, ашигт малтмал олборлох хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн тохиолдолд улсын хяналтад хамрагдах байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн ашиглалтыг илэрсэн зөрчлийг арилгах хүртэл түр хугацаагаар хориглон зогсоох, холбогдох шаардлага, шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааг бүрмөсөн зогсоох тухай шийдвэр гаргах;

б/ аюулгүй ажиллагаа болон эрчим хүч хэмнэх шаардлагыг хангаагүй тоног төхөөрөмж, хэрэгсэл, технологийг зураг төсөлд тусгах, ашиглах, гадаадаас оруулж ирэх, зохион бүтээх явдлыг хориглон зогсоох;

в/ улсын хяналтад хамаарах аж ахуйн нэгж, байгууллага, объект болон эрчим хүч хэрэгсэдэг айл өрхөд саадгүй нэвтрэн орж хяналт шалгалт явуулах;

г/ хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

д/ хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар улсын хяналтад хамаарагдах байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

е/ хяналтын алба шаардлагатай үед хяналт шалгалтын ажилд холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг тэдгээрийн удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр татан оролцуулах.

14. Хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн болон илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтанд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн зохих заалтын дагуу дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

а/ хайгуулын явцад ашигт малтмал олборлосон, борлуулсан, тусгай зөвшөөрөлгүйгээр хайгуул хийсэн орд ашигласан бол хууль бусаар олсон орлого буюу бүтээгдэхүүнийг хурааж, гэм буруутай иргэнийг 10000-40000, албан тушаалтныг 15000-60000, байгууллага аж ахуйн нэгжийг 60000-250000 төгрөгөөр торгох;

б/ ашигт малтмалын хайгуул, орд ашиглалтын тайлан мэдээг цаг тухайд гаргаж өгөөгүй, худал мэдээлж тайлагнасан албан тушаалтныг 10000-50000 төгрөгөөр торгох;

в/ хайгуулын талбайгаас авсан дээж сорьц, анхдагч материалыг санаатайгаар устгасан албан тушаалтныг 15000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 60000-250000 төгрөгөөр торгох;

г/ хайгуул олборлолтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол гэм буруутай албан тушаалтныг 5000-15000, байгууллага, аж ахуйн нэгжийг 30000-100000 төгрөгөөр торгох;

д/ орчныг хамгаалах, хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй, хүмүүсийн эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах байдлаар хайгуул хийсэн, ашиглалт явуулсан бол хохирлыг нөхөн төлүүлж, албан тушаалтныг 15000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 30000-100000 төгрөгөөр торгох;

е/ иргэн, хуулийн этгээдээс ашигт малтмалын хууль тогтоомжоор олгогдсон эрхээ эдлэхэд санаатайгаар саад учруулсан бол иргэнийг 5000-30000, албан тушаалтныг 15000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 30000-80000 төгрөгөөр торгох;

ж/ газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн бол иргэнийг 3000-30000, албан тушаалтныг 10000-40000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-200000 төгрөгөөр торгох;

з/ газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагсад, хүн ам болон мал, ан амьтан, бэйгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй бол иргэнийг 3000-30000, албан тушаалтныг 10000-40000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-200000 төгрөгөөр торгох;

и/ газар доорхи усны горимыг ажиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, гэмтээсэн бол иргэнийг 5000-30000 төгрөгөөр торгох;

к/ ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, түүнчлэн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга, байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар газрын хэвлийн хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-200000 төгрөгөөр торгох;

л/ газрын хэвлийг ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу болон шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах

шаардлагыг биелүүлээгүй бол иргэнийг 15000-40000, байгууллага, аж ахуйн нэгжийг 75000-200000 төгрөгөөр торгох;

м/ газрын хэвлийг дур мэдэн ашигласан, ашигт малтмал бүхий талбайд барилга, байгууламж дур мэдэн барьсан бол иргэнийг 20000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох;

н/ геологи, маркшейдерийн баримт бичгийг хөтлөөгүй буюу үргэлжлүүлсэн бол албан тушаалтныг 10000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох;

о/ газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үчлэл, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн бол 150000-250000 төгрөгөөр торгох;

п/ ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг бусад хэлбэрээр зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол 150000-250000 төгрөгөөр торгох;

р/ газрын хэвлийг ашиглах явцад өндэрсэн газрыг аюул осолгүй болгож, цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй бол иргэнийг 30000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох;

с/ цахилгаан, дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээ, зуух, гэрэлтат сав, шугам хоолой, шингэрүүлсэн шатдаг хий ашиглах явцад техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журмын зөрчил гаргасан иргэнийг 1000-30000, албан тушаалтныг 3000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 80000-250000 төгрөгөөр торгох;

т/ үйлдвэрлэлийн зориулалттай гэрэх материалын үйлдвэрлэл, хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт болон тээсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм, журам зөрчсөн иргэнийг 1000-20000, албан тушаалтныг 3000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 80000-250000 төгрөгөөр торгох;

у/ үйлдвэрлэлийн осол, аваарь, саатал гаргасан, түүний мөрөөр тодорхой ажил зохион байгуулаагүй, осол, аваарь, саатлыг судалж бүртгээгүй, нуун дарагдуулсан албан тушаалтныг 5000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох;

ү/ эрчим хүчийг гэрээгүйгээр ашиглах, гэрээнд зааснаас өөрөөр холболт хийх, эрчим хүчний тоолуурын байрлал, битүүмжлэл, эд анги, механизм, схемийн хэвийн ажиллагааг алдагдуулах зэргээр эрчим хүч ашиглах дүрэм, журмыг зөрчсөн бол хэрэглэсэн хугацааны эрчим хүчний үнийг нөхөн төлүүлж, гэм буруутай иргэнийг

1000-30000, албан тушаалтныг 3000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 20000-250000 төгрөгөөр торгох;

ф/ эрчим хүч зарцуулалтын норм хэмжээг хэтрүүлсэн, тайлан тооцоог хугацаанд нь гаргаж ирүүдээгүй, үйлдвэрлэл, борлуулалтын явцад хөтлөгдөх бичиг баримтыг будлиантуулсан албан тушаалтныг 3000-40000, байгууллага, аж ахуйн нэгжийг 10000-100000 төгрөгөөр төгрөгөөр торгох;

х/ цахилгаан, дулааны эрчим хүчийг хууль бусаар хулгайгаар ашигласан бол хэрэглэсэн хугацааны эрчим хүчний үнийг нөхөн төлүүлж, иргэнийг 10000-30000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох;

ц/ баталгаа зөвшөөрөлгүй, үйлдвэрийн бус хийцтэй цахилгаанаар халаах хэрэгсэл хэрэглэсэн бол уг хэрэгслийг хураан, хэрэглэсэн хугацааны эрчим хүчний үнийг нөхөн төлүүлж, иргэнийг 3000-30000, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000-250000 төгрөгөөр торгох;

ч/ үйлдвэр, байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийг чанаргүй эрчим хүчээр хангасан, мөн эрчим хүчний хангамжийг дур мэдэн тасалсан гэм буруутай албан тушаалтныг 10000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000-250000 төгрөгөөр торгох;

ш/ эрчим хүчээр хангагч байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгч, хяналтын улсын байцаагчийн шаардлагыг хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүдээгүй иргэнийг 1000-10000, албан тушаалтныг 3000-15000 төгрөгөөр торгох;

э/ улсын ерөнхий болон ахлах байцаагч нь хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-10000 төгрөгөөр, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтныг 15000 төгрөгөөр торгох;

ю/ хяналтын албаны болон улсын байцаагчдын албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүдээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүдээгүй, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон, хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн албан тушаалтныг 5000-50000 төгрөгөөр торгуулах асуудлыг шүүгчид тавьж шийдвэрлүүлэх;

я/ ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх.

Дөрөв. Бусад зүйл

15. Хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтан хутагцаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

16. Байцаагчийг байгууллага, аж ахуйн нэгжийн захиралга, дуудлагаар хяналт шалгалт, туршилтын болон осол аваарь тусгайлан судлах ажилд оролцуулбал тэдний зардал (унаа, байрны болон бусад зардал)-ыг захиалга, дуудлагаар ажилдуулсан байгууллага, аж ахуйн нэгж хариуцаж гаргана.

17. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтан байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно. Уг гомдлыг хүтээн авснаас хойш хяналт шалгалтын байгууллагын эрх баригч 30 хоногийн дотор хянан шийдвэртэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

18. Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид зассны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

1995 оны 10 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар  
хот

**Боловсролын улсын хяналтын  
дүрэм батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Боловсролын улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 261 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Шинжлэх ухаан, боловсролын сайд

**П.ЖАСРАЙ  
С.ТӨМӨР-ОЧИР**

## БОЛОВСРОЛЫН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

### НЭГ. Нийтлэг үндэстэл

1. Боловсролын улсын хяналтын зорилт нь Боловсролын тухай хууль тогтоомж, бүх шатны боловсролын стандарт, сургалт-хүмүүжлийн ажилтай холбогдсон норматив, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахад оршино.

2. Боловсролын улсын хяналтыг боловсролын улсын хяналтын алба, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын боловсролын хяналтын улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

3. Боловсролын улсын хяналтын албаны дарга нь боловсролын хяналтын улсын ерөнхий байцаагч байна. Боловсролын хяналтын улсын ерөнхий байцаагчийг шинжлэх ухаан, боловсролын асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд боловсролын хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4. Боловсролын хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг боловсролын хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор шинжлэх ухаан, боловсролын асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө.

Аймаг, нийслэлийн боловсролын хяналтын улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр байцаагчийн эрхийг шинжлэх ухаан, боловсролын асуудал эрхэлсэн сайд олгоно.

5. Боловсролын хяналтын улсын байцаагчид нь бүх шатны боловсролын стандарт, сургалт-хүмүүжлийн зэрэг боловсролын асуудлаар мэргэшсэн байна.

6. Боловсролын хяналтын улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

7. Боловсролын улсын хяналтын алба нь зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд боловсролын хяналтын улсын ерөнхий болон ахлах, улсын байцаагчид нь (шаашид байцаагч гэх) Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

## ХОЁР. Боловсролын улсын хяналтын чиглэл

8. Боловсролын хяналтыг дор дурдсан чиглэлтээр хэрэгжүүлнэ:

а/ боловсролын талаархи хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох шийдвэрийн хэрэгжилт;

б/ иргэдэд эзэмшүүлж байгаа сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролын зохион байгуулалт, стандартын хэрэгжилт, чанарын түвшин;

в/ албан бус боловсролын стандартын хэрэгжилт, мэргэжил олгох түр сургуулиар эзэмшүүлж байгаа мэргэжлийн мэдлэг чадвар, түвшин, чанар;

г/ шинжлэх ухаан, боловсролын сайдын шийдвэрээр батлагдсан дүрэм, журам, сургалт-хүмүүжлийн ажлын норм, нормативын хэрэгжилтэд судалгаа хийж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг боловсронгуй болгох саналаа зохих байгууллагад оруулах;

д/ боловсролын байгууллагыг холбогдох байгууллагуудтай хамтран аттестагчилж, тухайн байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлын шалтгааныг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээний хэрэгжилт;

е/ мэргэжлийн олон нийтийн байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн болон магадлан итгэмжлэх байгууллагуудтай хамтран боловсролын чанарыг үнэлж дүгнэх хэлбэр, арга хэрэгслийг боловсронгуй болгох, энэ чиглэлээр сургууль, багш нарт туслал, тест, оношилгооны сан бүрдүүлэлт;

ж/ нийгэм, иргэдийн эрх ашгийг хохироох, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх сургалтыг зохион байгуулж байгаа эсэх.

9. Аймаг, нийслэлд ажиллаж байгаа улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг боловсролын улсын хяналтын алба хэрэгжүүлнэ.

## ГУРАВ. Боловсролын хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

10. Боловсролын хяналтын улсын байцаагч нь энэ дүрмийн 8 дугаар зүйлд заасан үүргийг гүйцэтгэнэ.

11. Боловсролын хяналтын улсын байцаагч дор дурдсан эрх эзэлнэ:

а/ Төрийн хяналт шалгалтын болон Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, бүх шатны боловсролын стандарт, сургалт-

хүмүүжлийн ажилтай холбогдсон норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих;

б/ сургалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургуулийн долоод дүрэм, сургалтын үйл явц, үр дүнг шалгаж үнэлэх шалгалт, шүүлгийн дүрэм болон зайлшгүй шаардлагатай бусад мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт зэргийг боловсролын байгууллага, холбогдох төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

в/ холбогдох байгууллагатай нь тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах үүднээс магадлан шонжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

г/ төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага аж ахуйн нэгж, иргэдээс журам, дүрмийг зөрчиж хууль бусаар сургалтыг зохион байгуулж олсон орлого, эд хөрөнгийг зохих баримт бичиг бүрдүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод оруулах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шүүхийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

д/ хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтанд шаардлага тавьж хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

е/ зэрэглэлдээ тохирсон боловсролын агуулгын стандартын түвшинг хангаагүй, эсвэл хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд сургалтын байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох.

12. Боловсролын хяналтын улсын байцаагч нь гэм буруутай этгээдэд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Боловсролын хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн дор дурдсан захиргааны шийтгэл торгууль ногдуулна:

а/ иргэдэд суурь боловсрол олгох ажлыг хангалтгүй зохион байгуулсан, зохих арга хэмжээг аваагүй төрийн захиргааны гэм буруутай албан тушаалтныг 15000 төгрөгөөр, боловсролын байгууллагын албан тушаалтныг 10000 төгрөгөөр торгох;

б/ боловсролын баримт бичгийг хууль бусаар олгосон гэм буруутай этгээдийг 10000 төгрөгөөр, хуурамчаар үйлдсэн гэм буруутай этгээдийг 25000 төгрөгөөр тус тус торгож хуурамч баримт бичгийг хураах;



в/ сургалтын байгууллагын барилга, байгууламжийг зориулалтын дагуу ашиглаагүйн улмаас нийгэм, иргэдэд хохирол учруулсан гэм буруутай албан тушаалтныг 30000-40000 төгрөгөөр торгох;

г/ хүүхдэд 17 хүртэлх насанд нь суурь боловсрол завал эзэмшүүлэх тухай Боловсролын тухай хуулийн заалтыг зөрчиж хүндэтгэх шалтгаангүйгээр хүүхдээ сургууль завсардуулсан эцэг эх, асран хамгаалагчдыг 10000-25000 төгрөгөөр торгох;

д/ зохих гэрээний дагуу суралцагчдыг хүлээж авч үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл бололцоогоор хангах үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн албан тушаалтныг 25000-35000 төгрөгөөр, биелүүлээгүй албан тушаалтныг 40000-50000 төгрөгөөр торгох;

е/ тусгай зөвшөөрөлгүйгээр сургалт-хүмүүжлийн ажил эрхэлсэн гэм буруутай этгээдийг шалтгаан нөхцөл байдлыг нь харгалзан 20000-50000 төгрөгөөр торгох;

ж/ сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүдэлгүй үйл ажиллагаа явуулсан гэм буруутай этгээдийг 40000-50000 төгрөгөөр торгох;

з/ сургалтын үйл ажиллагаанаас өөр төрлийн үндсэн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлсэн бол олсон орлогыг хурааж, сургалтын байгууллагыг шалтгаан нөхцөл байдлыг нь харгалзан үзэж 150000-250000 төгрөгөөр торгох;

и/ хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах болон суралцагчдын амралтын хугацааг хууль бусаар өөрчилсөн, хичээлийг түр хугацаагаар хаасан гэм буруутай албан тушаалтныг 15000-25000 төгрөгөөр торгох;

к/ оюутан, сурагчид элсүүлэх журам зөрчсөн, зөрчих боломж олгосон гэм буруутай этгээдийг эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй гэж үзвэл 5000-20000 төгрөгөөр торгох;

л/ мэргэжлийн түр сургалт зохион байгуулах, зөвшөөрөл олгох журам зөрчиж нийгэм, иргэдэд хохирол учруулсан сургалт зохион байгуулсан гэм буруутай этгээдийг 25000-50000 төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хурааж;

м/ боловсролын хяналтын улсын ерөнхий, ахлах байцаагч нар хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтанд 5000-10000, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтанд 15000 хүртэл төгрөгийн торгууль ногдуулах;

н/ шалгалтын явцад шалгуулагч байгууллага, иргэд, албан тушаалтан боловсролын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон, хяналт

шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн зөрчил илэрвэл 5000-50000 төгрөгөөр торгуулахаар асуудлыг шүүхэд тавьж шийдвэрлүүлэх.

### ДӨРӨВ. Бусад зүйл

13. Боловсролын улсын хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хутагтаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

14. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно.

Уг гомдлыг хүтээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно.

15. Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүтээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 10 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар  
хот

Эрүүл ахуй, халдвар судлал, эм,  
биобэлдмэлийн улсын хяналтын  
дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын дүрэм"-ийг 1 дүгээр хавсралтын, "Эм, биобэлдмэлийн улсын хяналтын дүрэм"-ийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 149 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Эрүүл мэндийн сайд

П.НЯМДАВАА

Засгийн газрын 1995 оны 192 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР СУДЛАЛЫН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын зорилт нь нийгэм, ахуй, байгаль орноос хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлдэг буй хүчин зүйлсийг илрүүлэх, тандах, түүнээс шалтгаалсан өвчин, эмгэгийг судалж, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн захиргааны мэргэжлийн хяналтыг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад оршино.

2. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтыг Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын алба, аймаг, нийслэл, сум, дүүргийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагч хэрэгжүүнэ.

Шаардлагатай бол зарим яам, тусгай газар, байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагч ажиллуулж болно.

3. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны дарга нь эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагч байна. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагчийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөтнө.

5. Аймаг, нийслэл, яам, газарт ажиллах эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ахлах байцаагчийг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагчтай зөвшилцсөний үндсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга, сайд, газрын дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын ахлах байцаагчийн эрхийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайд олгоно.

Аймаг нийслэл, яам, газар, байгууллага, аж ахуйн нэгжид ажиллах эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагчийг ту-

хайн орон нутаг, яам, газрын улсын ахлах байцаагчтай зөвшилцөж, зохих шатны Засаг дарга, сайд, газрын дарга нар томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагч олгоно.

6. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтад хамрагдах объектын жагсаалтыг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагч батална.

7. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагчид нь эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын асуудлаар мэргэшсэн байна.

8. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын алба, эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

9. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагчид /шашид байцаагч гэх /нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, албан шаардлага, акт, дүгнэлт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

#### **ХОЁР. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын чиглэл**

10. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтыг дор дурасан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ эрүүл ахуй, халдвар судлалын талвархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт;

б/ манай улс нэгдэн орсон олон улсын эрх бүхий байгууллагаас баталж, нийтлэг мөрдөж байгаа болон манай улсын өөр улстай байгуулсан эрүүл ахуй, халдвар, нян, хор судлалын холбогдолтой конвенц, гэрээ, эрх зүйн бусад актуудын биелэлт;

в/ хот, суурин, байгууллага, аж ахуйн нэгжийг байгуулах ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн болон технологийн зураг төсөл зохиох, газар сонгох, тэдгээрийг барьж байгуулах, ашиглалтад оруулахад мөрдөх эрүүл ахуйн норм, нормативын биелэлт;

г/ үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмж, тэдгээрийн технологийн ажиллагаа, түүхий эд, бүтээгдэхүүн, ундны болон ахуйн хэрэглээний ус, хүнсний зүйл зэргээс хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэж байгаа эсэх;

д/ нийгэм, ахуй, байгаль орчны нөхцөлөөс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөг илрүүлэх, арилгах;

е/ хоол, хүнсний зүйлийн чанар, түүний баталгаажилт, эрүүл ахуйн аюулгүй байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөлөл;

ж/ халдварт, байгалийн голомтот, гоц аюулт халдварт өвчин гарч, тархаж байгаа нөхцөл шалтгааныг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эдгээр өвчинтэй тэмцэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн хууль, тогтоомжийн хэрэгжилт;

з/ ахуйн хортон шавьж, мэрэгчтэй тэмцэх болон ариутгал, халдваргүйтгэлийн ажлын чанар;

и/ өргөн тархмал болон нутагшмал өвчин эмгэг, гэмтэл, хордлогын тархалт, шалтгаан, сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хэрэгжилт;

к/ улсын хилийн эрүүл ахуй, халдвар судлалын аюулгүй байдал болон хилээр нэвтрүүлэх бараа материал, тээврийн хэрэгсэл, зорчигчдоос мөрдөх эрүүл ахуй, халдвар судлалын арга хэмжээний хэрэгжилт;

л/ тамхи, архины хорт нөлөөллөөс сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний хэрэгжилт.

11. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, яам, газарт ажиллаж байгаа эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын алба хариуцан хэрэгжүүлнэ.

### **Гурав. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх**

12. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагч нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хийж, эрүүл ахуйн магадлгаа шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргах, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх хүчин зүйлээс сэрэмжлүүлж, илэрсэн зөрчлийг шуурхай арилгах арга хэмжээ авах, хяналтын үр дүнг мэдээлэх, сурталчлах;

б/ урьдчилан сэргийлэх тарилгын үйлдвэрлэлт, хадгалалт, тээвэрлэлт, тарилгын хөтөлбөрийн хэрэгжилт, хүн амын дархлалын түвшингийн байдалд хяналт тавих;

в/ хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хохирол учруулж болох, учруулсан нь нотлогдсон үйлдвэр, үйлчилгээний үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түр зогсоож, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

г/ хүн амын эрүүл мэнд, удамшилд гаж нөлөөлөх бүтээгдэхүүн, бодис, цусны бүтээгдэхүүн, донор эд эрхтэн, бэлдмэлүүдийг хэрэглэх, улсын хилээр нэвтрүүлэх, худалдаалахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харцлахагүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах;

д/ эрүүл ахуй, халдвар судлалын хэм хэмжээг сахиулахад чиглэсэн дүрэм, журам, гарын авлагыг мөрдүүлэх, нийтийн хүртээл болгох, биелэлтийг хянах, хяналтын ажлын үр дүнг олон түмэнд хүргэж, мэдээлэх;

е/ хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлдөг шаираг идэхт болон химийн бодис, цахилгаан соронзон орны үүсгүүр, нянгийн амьд өсгөөр, тэдгээрийн хор, хүнсний нэмэлт, мал, газар тариалан, хортон шавьжтай тэмцэх бодис, пестицидийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлтийн байдалд хяналт тавих, тэдгээрийн нөлөөллөөр үүсэж болзошгүй өвчин, эмгэгийг судлах, тандах, сэргийлэх арга хэмжээ авах;

ж/ ахуйн орчин, хоол хүнс, хөдөлмөр, сургалтын хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас хүний эрүүл мэндэд учруулж буй хор холбогдол, өвчин эмгэг, халдварт өвчний гаралт, тэрхалтын шалтгааныг судалж, тандах, урьачилан сэргийлэх арга хэмжээний чиглэл боллогыг тодорхойлох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

з/ хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд акт, албан шаардлага бичиж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах.

### 13. Байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/ биобэлдмэл, хор, бордоо, нийлэг эдлэл, хувцас, тоглоом, хичээлийн хэрэгтэл, хүнс, хүнсний нэмэлт, гоо сайхан, ахуйн зориулалттай бараа, ариутгалын бодис, үйлдвэртэл, ахуйн зориулалтаар хэрэглэх химийн бодис, барилгын материал, сав, баглаа, боодол эрүүл ахуйн магадлагаа шинжилгээ хийлгэж, эрүүл ахуйн гэрчилгээ олгуулах, гэрчилгээгүй бүтээгдэхүүнийг хэрэгцээнд гаргахыг хориглох;

б/ Монгол улсын нутаг дэвсгэрт олон улсын хөл хориот болон бусад халдварт өвчин тархахаас сэргийлэх зорилгоор шаардлагатай үед аймаг, нийслэл, сум, дүүрэгт иргэдийн зорчих хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох хүртэл арга хэмжээ авах асуудлыг холбогдох байгууллагад тавих;

в/ халдварт өвчтэй хүн, халдварт өвчний нян тээгч, дамжих замыг бүрдүүлэгчид, тэдэнтэй хавьтагсад халдвар тараах аюултай бол тусгаарлах, хөл хорих, эмчлүүлэх, эмнэлгийн магадлагаа гаргуулах,

ажил, хичээлээс чөлөөтүүлэх, хөдөлмөр зохицуулалт хийлгэх, энэ шаардлагыг биелүүлэхээс татгалзсан этгээдийг албадан шинжилж, эмчлүүлэх (шаардлагатай бол цагдаагийн байгууллагын туслалцаа авч гүйцэтгэх);

г/ энэ дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар нутгийн захиргааны болон харьяалах төрийн захиргааны төв байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх;

д/ хүний амь нас, эрүүл мэнд, үйлдвэртэй, үйлчилгээ, нийгэм ахуй, хөдөлмөр, сургалтын орчинд хортой нөлөө үзүүлэх хими, биологи, физикийн сөрөг хүчин зүйл, бодис бэлдмэл, техник технологийг зохих шинжилгээ, дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр хэрэглэж нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хэрэглэхийг хориглох, устгах, хууль бусаар олсон ашгийг улсын орлогод оруулах, нөхөн төлбөр ногдуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

е/ шаардлагатай асуудлаар холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр шинжээчийн хэсэг томилох, холбогдох лабораториудаар хяналт, шинжилгээ хийлгэн, магадалгаа, дүгнэлт гаргуулах;

ж/ эрүүл ахуй, халдвар судлалын хяналт шалгалттай холбогдсон мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулж авах;

з/ бүтээгдэхүүний дээж, загварыг тэмдэглэл үйлдэн захиргааны эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо хэмжээний дагуу авч шинжлүүлэх.

14. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагч нь гэм буруутай этгээдэд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны хариуцлагын, Хүнсний, Хөдөлмөрийн, Химийн хорт бодисоос хамгаалах, Агаарын, Тамхины хор хөнөөлтэй тэмцэх, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, Архидан согтуурахтай тэмцэх тухай зэрэг хуулийн заалтыг үндэслэн дараахь захиргааны шийтгэл, торгууль ногдуулна:

а/ хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг хүчин зүйл нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрч, хүн амыг өвчлүүлж эрүүл мэндийг хохироосон нь тогтоогдсон бол гэм буруутай иргэнийг 10000-20000 төгрөгөөр, албан тушаалтныг 15000-25000 төгрөг, байгууллага, аж ахуйн нэгжийг 30000-50000 төгрөгөөр тус тус торгох;

б/ олон хүнийг хамарсан хордлого гаргасан бол иргэн, албан тушаалтныг 30000, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000 төгрөгөөр торгох;

в/ эрүүл ахуйн шаардлага хангахгүй бүтээгдэхүүн импортлосон бол уг бүтээгдэхүүнийг худалдахыг хориглох, устгах, гэм буруутай

иргэдийг 10000-40000 төгрөг, албан тушаалтанг 30000-35000 төгрөг, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-200000 төгрөгөөр торгох;

г/ хүн амын дунд халдварт өвчин тараах нөхцөл бүрдүүлсэн иргэдийг 5000-15000 төгрөг, албан тушаалтанг 15000-20000 төгрөг, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-70000 төгрөгөөр торгох;

д/ эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч нь хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтанд 5000-10000, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтанд 15000 хүртэл төгрөгийн торгууль ногдуулах;

е/ хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт шийдвэрт нөлөөлөхийг оролдсон, хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн этгээд, албан тушаалтныг 5000-50000 төгрөгөөр торгуулах саналва шүүгчид тавьж шийдвэрлүүлэх.

### Дөрөв. Бусад зүйл

15. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтан хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

16. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтан байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд гомдлоо 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно. Уг гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

17. Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Засгийн газрын 1995 оны 192 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## ЭМ, БИОБЭЛДМЭЛИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Эм биобэлдмэлийн улсын хяналтын зорилт нь эмийн түүхий эдийг импортлох, экспортлох, Монгол Улсын хүн эмнэлгийн практикт хэрэглэж байгаа эм, биобэлдмэл, эмийн түүхий эд, уламжлалт эм тангийн чанарыг баталгаажуулах, эх орны эм, биобэлдмэлийн үйлдвэрийн технологи, улсын стандарт, түүнтэй адилтгах техникийн баримт бичгийн мөрдөлт, эм, биобэлдмэлийн худалдаа, хэрэглээнд мэргэжлийн хяналт тавих, эмийн импорт, экспорт, үйлдвэрлэл, хэрэглээ, худалдаатай холбогдолтой Монгол Улсын хууль тогтоомж, норм, нормативыг нийт байгууллага, иргэдээс сахин мөрдүүлэхэд оршино.

2. Эм, биобэлдмэлийн улсын хяналтыг улсын эм, биобэлдмэлийн хяналтын алба, аймаг, нийслэлийн эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч нар хэрэгжүүлнэ.

3. Эм, биобэлдмэлийн хяналтын албаны дарга нь эм, биобэлдмэлийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна. Эм, биобэлдмэлийн хяналтын улсын ерөнхий байцаагчийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд эм, биобэлдмэлийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4. Эм, биобэлдмэлийн хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг эм, биобэлдмэлийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө.

Аймаг, нийслэлд ажилдаж байгаа эм, биобэлдмэлийн улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд гэдгээр байцаагчийн эрхийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайд олгоно.

5. Эм, биобэлдмэлийн улсын байцаагчид нь эм, биобэлдмэлийн хяналтын асуудлаар мэргэшсэн байна.

6. Эм, биобэлдмэлийн хяналтын алба, эм, биобэлдмэлийн улсын байцаагчид үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

7. Эм, биобэлдмэлийн улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагчид (цаашид "байцаагч" гэх) нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, албан шаардлага, акт, устгалын тэмдэглэл, шийтгэвэр, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### ХОЁР. Эм, биобэлдмэлийн улсын хяналтын чиглэл

8. Эм, биобэлдмэлийн улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ эх орны болон импортын эм, биобэлдмэлийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох ажил;

б/ эм, биобэлдмэлийн үйлдвэрлэлийн технологи, чанарыг шалгах техникийн баримт бичгийн судалгаа дүгнэлт;

в/үндэсний зайлшгүй шаардлагатай эм, биобэлдмэлийн жагсаалтын хяналт, санал дүгнэлт;

г/ эм, биобэлдмэл, уламжлалт эм тан, эмийн түүхий эдэд хийх хими, биологи, хор судлал, микробиологи, ургамал судлалын лабораторийн шинжилгээ, чанарын баталгаа;

д/ эмийн сангийн эм шинжилгээний кабинет, эмийн үйлдвэрийн чанарын тасгийг эмийн чанарын шинжилгээний урвалж бодисоор хангах ажил;

е/ эм, биобэлдмэлийн үйлдвэрлэлийн технологи, чанарын хяналтын холбогдолтой дүрэм, журам, зааврын мөрдөлт;

ж/ эм, биобэлдмэлийн үйлдвэрлэл, чанар, мансууруулах ба сэтгэц нөлөөт эмийн хяналтын асуудлаар олон улсын болон сонирхогч орны холбогдох байгууллагатай харилцах, мэдээлэл солилцох зэрэг хамтын ажиллагаа;

з/ эм, биобэлдмэлийн хэрэглэх хугацаанд тавих хяналт.

9. Аймаг, нийслэлд ажиллаж байгаа эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагчид эмийн сан, эмийн үйлдвэрийн эм шинжлэгчдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг эм, биобэлдмэлийн улсын хяналтын алба хариуцан хэрэгжүүлнэ.

### ГУРАВ. Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

10. Байцаагч дор дурдсан асуудлаар хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэнэ:

а/ хүний эм, биобэлдмэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох буюу худалдах эрхийн зөвшөөрөлтэй эсэхэд хяналт тавих;

б/ үйлдвэрлэл явуулж байгаа орон байр, үйл ажиллагааны чиглэл эрхийн зөвшөөрлийн заалттай нийцэж байгаа эсэхийг хянах;

в/ импортын болон эх орны эм, биобэлдмэл, эмийн түүхий эд нь чанарын баталгаатай эсэх;

г/ хүний эмийн үйлдвэрлэл явуулах байр, тоног төхөөрөмж, мэргэжилтний хангамж, стандарт, техникийн нөхцөл болон технологийн горимын мөрдөлтийг хангуулах;

д/ мансууруулах ба сэтгэц нөлөөг болон хүчтэй эмийн зэрцуулэлт, түүний хэрэглээг хянах;

е/ эм биобэлдмэлийн хэрэглэх хугацаанд хяналт тавих;

ж/ эм, биобэлдмэлийн дахин буюу жижиглэн савлалтын чанар, хаяглалт, хадгалалтыг шалгах;

з/ эмийн санд бэлтгэж байгаа эм, тарилгын шингэн, нэрмэл усны чанар, хаяглалт, хадгалалт, хүчинтэй байх хугацааг хянах;

и/ эмнэлгийн байгууллага, эмийн сангийн эмийн нэр төрөл, зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, эм олголт, эмийн жор мөрдөлтөд хяналт тавих;

к/ эм, биобэлдмэлийн тээвэрлэлт, хадгалалтын шаардлагыг мөрдүүлэх;

л/ хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд тавьсан шаардлага, хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах.

11. Байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/ эм, биобэлдмэлийн стандарт, техникийн нөхцөлийн шаардлага хангаагүй эм, биобэлдмэл, уламжлалт эм тан үйлдвэрлэх, найруулан бэлтгэх, худалдах ажиллагааг зогсоох, дахин боловсруулалт, савлалт хийлгэх буюу актлан устгуулах;

б/ Монгол Улсын эмийн бүртгэлд ороогүй буюу тухайн үед зөвшөөрөгдөөгүй эм, биобэлдмэл, түүхий эд, дорно дахины эмийн бэлдмэлийг импортлосон буюу худалдсан, мөн хугацаа дууссан, хуурамч, дууриамал эм худалдсан тохиолдолд тухайн эмийг хураан устгах шийдвэр гаргах, хэрэв тэдгээрийг худалдан бортуулсан бол түүний орлогыг хурааж улсын орлого болгох;

в/ тухайн бүтээгдэхүүний импорт, экспорт, хэрэглээтэй холбоотой баримт материалыг нарийвчлан шалгах, дүгнэлт шинжилгээ хийлгэх, мэдээ, судалгаа гаргуулах;

г/ шинжилгээний зориулалтаар эм, биобэлдмэл, эмийн түүхий эд, уламжлалт эм тангаас хүрэлцэхүйц хэмжээний дээжийг үнэ төлбөргүй авах;

д/ үйлдвэрлэлийн технологи, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн удаа дараа үйлдвэрлэсэн буюу хуурамч, дууриамал эм давтан худалдсан үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эмийн сангийн эрхийг хүчингүй болгох асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

е/ холбогдох байгууллагатай нь тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах, лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

ж/ эм, биобалдмэлийн хяналт шалгалтын ажилд шаардлагатай гэдгээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

з/ хяналт шалгалтын дүнгийн талаар хэвтэл, радио, телевизээр мэдээлэх.

12. Мансууруулах ба сэтгэц нөлөөт эмийг импортлох, худалдах үйл ажиллагаатай холбогдон илэрсэн зөрчлөөс бусад тохиолдолд буруутай этгээдэд Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль болон Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн заалтыг үндэслэн дараахь захиргааны шийтгэл, торгууль ногдуулна:

а/ зохих эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, улсын бүртгэлд ороогүй, чанарын баталгаажуулалт хийгдээгүй эм, биобалдмэл, түүхий эдийг импортолсон, экспортолсон, хэрэглэсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 5000-25000, албан тушаалтныг 10000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 60000-150000 төгрөгөөр торгох;

б/ зохих зөвшөөрөлгүй буюу эрх бүхий байгууллагын хориглосон газарт болон тухайн ажилтны албан тушаалын үүрэгт заагдаагүй үйлчилгээ явуулсан бол гэм буруутай этгээдийг 1000-20000, байгууллага, аж ахуйн нэгжийг 10000-60000 хүртэл төгрөгөөр торгох;

в/ стандартын бус бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн буюу стандартын үзүүдэлт шаардлагыг зөрчсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, хэрэглэсэн, худалдсан тохиолдолд хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 15000-25000, албан тушаалтныг 20000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-150000 төгрөгөөр торгох;

г/ хэрэглэх хугацаа дууссан эм, биобалдмэлийг эмчилгээнд хэрэглэсэн буюу хэрэглэхээр завдсан, худалдсан тохиолдолд байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-150000 хүртэл төгрөгөөр, худалдсан иргэнийг 5000-25000 төгрөгөөр торгох;

д/ эм, биобалдмэл, түүхий эдийн нэр хаяг, савталт, тээвэрлэх, хадгалах нөхцөл, тухайн техникийн баримт бичгийн шаардлага, стандарт зөрчсөн, хуурамч буюу дууриамал эм хэрэглэсэн, худалда-

сан, эмнэлэгт эм сольж хэрэглэсэн тохиолдолд гэм буруутай этгээдийг 1000-20000, албан тушаалтныг 5000-25000, байгууллага, аж ахуйн нэгжийг 30000-75000 төгрөгөөр торгох;

е/ улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч нь хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-10000 хүртэл төгрөгөөр, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтныг 15000 хүртэл төгрөгөөр торгох;

ж/ хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон, хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргасан этгээд, албан тушаалтныг 5000-50000 төгрөгөөр торгуулах саналаа шүүгчид тавьж шийдвэрлүүлэх;

з/ мансууруулах ба сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээ бүхий эмийг импортлох, хэрэглэхтэй холбогдон илэрсэн зөрчил нь эрүүгийн хариуцлагын шинжтэй гэж үзвэл энэ тухай асуудлыг хянан шийдвэрлүүлэхээр хуулийн байгууллагад шилжүүлэх.

### ДӨРӨВ. Бусад зүйл

13. Эм, биобэхдмэлийн улсын хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтан хугацаанд нь биелүүлж хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

14. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд гомдлоо 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно.

Уг гомдлыг хүлээн авнаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

15. Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 10 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 193

Улаанбаатар  
хот

### Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 262 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд

Э. ГОМБОЖАВ

Засгийн газрын 1995 оны 193 дугаар  
тогтоолын хавсралт

## ХӨДӨЛМӨРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хөдөлмөрийн улсын хяналтын зорилт нь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт үйлдвэртэл, үйлчилгээ явуулж байгаа хамтын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн стандартын шаардлагыг хангуулахад оршино.

2. Хөдөлмөрийн улсын хяналтыг хөдөлмөрийн улсын хяналтын алба, аймаг, нийслэлийн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

3. Хөдөлмөрийн улсын хяналтын албаны дарга нь хөдөлмөрийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна. Хөдөлмөрийн хяналтын улсын ерөнхий байцаагчийг хүн амын бодлого, хөдөлмөрийн асуу-

дал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд хөдөлмөрийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4. Хөдөлмөрийн хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг хөдөлмөрийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор хүн амын бодлого, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө. Аймаг, нийслэлд ажиллах хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр байцаагчийн эрхийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайд олгоно.

5. Ажил төрлийн онцлог байдлаас шалтгаалан зарим яам, тусгай газарт хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч ажиллуулж болно. Яам, тусгай газарт хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийг сайд, тусгай газрын дарга нар нь томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр байцаагчийн эрхийг нь хүн амын бодлого, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайд олгоно.

6. Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид нь хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй зэрэг хөдөлмөрийн асуудлаар мэргэшсэн байна.

7. Хөдөлмөрийн улсын хяналтын алба, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

8. Хөдөлмөрийн хяналтын улсын ерөнхий болон ахлах байцаагч, улсын байцаагчид /шашид "байцаагч" гэх/ нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, шийтгэврийн хэлтэмэл хуудас хэрэглэнэ.

#### Хоёр. Хөдөлмөрийн улсын хяналтын чиглэл

9. Хөдөлмөрийн улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ Хөдөлмөрийн хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдож Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан тогтоол, холбогдох бусад шийдвэрийн хэрэгжилт;

б/ хөдөлмөрийн хөлс /орлого/, нэмэгдэл хөлс, нөхөн олговрын холбогдолтой хууль тогтоомж, холбогдох бусад шийдвэрийн мөрдөлт, хэрэгжилт;

в/ хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлагатай холбогдсон хууль тогтоомж, холбогдох бусад шийдвэрийн мөрдөлт, хэрэгжилт;

г/ ажиллах хүчний ашиглалт, хөдөлмөр эрхлэлтийн талаархи хууль тогтоомж, холбогдох бусад шийдвэрийн хэрэгжилт;

д/ хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай Монгол Улсын хууль, түүнийг хэрэгжүүлэх талаар Засгийн газар, эрх бүхий бусад байгууллагаас гаргасан тогтоол, холбогдох бусад шийдвэрийн биелэлт;

е/ хөдөлмөрийн стандартын хэрэгжилт, хөдөлмөрийн нөхцөл, техникийн аюулгүй ажиллагаа нь улсын стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд тавих хяналт, дүгнэлт;

ж/ хөдөлмөр хамгааллын хийгээд бие хамгаалах зориулалтын хувцас, хэрэгслийн чанар, стандарт, хүрэлцээ хангамж, ариутгах болон цэвэрлэх бодис, угаах, хамгаалах бодисын хадгалалт, олголт, хэрэглээний байдал, хоол, сүү, ус, шай олгох шаардлага хэрэгцээ, түүнийг хангах талаар авч байгаа арга хэмжээг шалгаж эвлэрчлэх, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ;

з/ тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны шаардлагад тохирч байгаа эсэх, материал, түүхий эд, бүтээгдэхүүн нь ажиллагчийн биед хортой нөлөө үзүүлдэг байгаа эсэх, мэргэжлийн өвчлөлийн байдал, эрүүдгүүдэх арга хэмжээ, түүний үр дүн;

и/ эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр хамгаалалттай холбогдсон хууль тогтоомж, холбогдох бусад шийдвэрийн хэрэгжилт;

к/ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар хяналт тавьж, хүний амь үрэгдүүлсэн, хүнд, бүлэг үйлдвэрлэлийн ослын талаархи судалгаа, бүртгэл, дүгнэлт.

10. Аймаг, нийслэлд ажиллаж байгаа байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг Хөдөлмөрийн улсын хяналтын алба хариуцан хэрэгжүүлнэ.

### Гурав. Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

11. Байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ энэ дүрмийн 9 дүгээр зүйлд заасан чиглэлийн дагуу хөдөлмөрийн улсын хяналтыг зохион байгуулж явуулах;

б/ үйлдвэр, аж ахуйн зориулалт бүхий барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, технологийн тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийхэд оролцож ашиглах буюу ашиглалтад хүлээн авах талаар зөвшөөрөл олгох;

в/ үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн актыг судалж хянах, хүний амь нэс хохироосон буюу хүнд, бүлэг ослыг газар дээр нь



тусгайлан судалж бүртгэн акт тогтоох, ослын уршгийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

г/ хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн стандартын хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргах;

д/ байгууллага, аж ахуйн нэгжийн дарга /эзэн/, ажилчдад хяналт шалгалтын үр дүнгийн талаар мэдээлэл, зөвлөлгөө өгөх, албан шаардлага гардуулж хугацаатай үүрэг өгөх;

е/ хяналт шалгалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгжийн үйлдвэртэл, технологийн нууцыг чанд халгалах;

ж/ хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх, байгууллага, албан тушаалтны нэр хүндийг хүндэтгэх;

з/ хяналт шалгалтын явцад хийсэн дүгнэлт, албан шаардлага, шалгалтын тоо баримтын үнэн зөвийг бүрэн хариуцах;

и/ үйлдвэртэлийн ослын мэдээг байгууллага, аж ахуйн нэгжээр гаргуулан авч нэгтгэх, мэдээлэх.

12. Байцаагч дор дурдсан эрх эдэлнэ.

а/ байгууллага, түүний нэгжийн ажлын нөхцөл, машин, тоног төхөөрөмжийн ажиллагаа нь ажилтны амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулж болзошгүй байвал уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд байгууллагын үйл ажиллагааг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны шийдвэрээр, түүний нэгжийн үйл ажиллагааг хөдөлмөрийн улсын байцаагчийн шийдвэрээр тус тус тодорхой хугацаагаар зогсоох;

б/ хөдөлмөрийн нөхцөл болон стандартын шаардлагыг хангаагүй ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийг ажилчин, албан хаагчдад олгохыг хориглох;

в/ ноштой аюул осол гарсан, хүний амь, эрүүл мэнд хохирсон, учруулсан хохирол нь нийгмийн хор аюул ихтэй бол шалгалтын акт, материалыг хуулийн байгууллагад шилжүүлэх;

г/ байгууллага, аж ахуйн нэгжийн ашиглаж байгаа болон үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байгаа нь шалгалтаар нотлогдвол түүнийг ашиглахыг зогсоож энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх;

д/ албан үүргээ гүйцэтгэх зорилгоор үйлдвэртэл, үйлчилгээ явагдаж байгаа ажлын байр, талбайд саадгүй нэвтрэн орох;

е/ хяналт шалгалтын ажилтай холбогдсон шаардлагатай бичиг баримт, дүгнэлт, мэдээ, судалгаа, тодорхойлолтыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтнаас гаргуулж авах;

ж/ холбогдох байгууллагын удирдлагатай гохиролцсоны үндсэн дээр зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажил татан оролцуулах, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, шинжээчийг томилон ажиллуулах;

з/ хяналт шалгалтаар илэрсэн дутагдал зөрчлийг арилгах талаар байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг хангуулах;

и/ хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн стандартыг зөрчиж гаргасан байгууллагын шийдвэрийг мөрдөхийг түдгэлзүүлэх.

13. Байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн болон илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, гэм буруутай этгээдэд Хөдөлмөрийн хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтыг үндэслэн дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

а/ үйлдвэрлэлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүд ахуйн холбогдох дүрэм, журмыг удаа дараа зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан ажилтныг 1000-30000, албан тушаалтныг 3000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 80000-250000 төгрөгөөр торгох;

б/ тодорхой хугацаагаар зогсоосон үйлдвэрлэлийн байрны ажлын нөхцөл, машин, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зөрчлийг арилгаж, эвсгөөрөл авахгүйгээр үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ажилтныг 15000-30000, албан тушаалтныг 10000-80000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох;

в/ тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхит бодис, хими, биологи, физикийн хортой нөлөөлөлтэй бодисыг хадгалах, ашиглах, тээвэрлэх, бэлтгэн нийлүүлэх журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан ажилтныг 1000-3000, албан тушаалтныг 5000-50000, байгууллага, аж, ахуйн нэгжийг 60000-200000 төгрөгөөр торгох;

г/ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам зөрчигдөж үйлдвэрлэлийн осол гарсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол ажилтныг 5000-50000, албан тушаалтыг 15000-60000 төгрөгөөр торгох;

д/ байгууллага, аж ахуйн нэгжид болон хувиараа хөдөлмөр эрхлэх явцад хөдөлмөр хамгааллын журмыг сахин хангуулах эрх бүхий этгээд энэ үүргээ биелүүлээгүй буюу хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам зөрчигдөж буйг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээ аваагүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000 40000 төгрөгөөр торгох;

е/ хөдөлмөрийн болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалтыг хэрэгжүүлээгүй, эсхүл эдгээр хууль тогтоомж зөрчиж ажилтны эрх ашгийг хохироо-

сон бол зөрчил гаргасан албан тушаалтныг 1000-40000 төгрөгөөр торгох;

ж/ үйлдвэртөлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийн ашиглалтад аюулгүй ажиллагааны зөвшөөрөл авахаас үндэслэлгүйгээр татгалзсан албан тушаалтныг 5000-50000 төгрөгөөр торгох;

з/ улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-10000, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлтэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтныг 15000 хүртэл төгрөгөөр торгох;

и/ хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр торгох, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон этгээдийг 35000 хүртэл төгрөгөөр торгох, хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр торгуулах саналаа шүүгчид тавьж шийдвэртүүлэх.

#### Дөрөв. Бусад зүйл.

14. Хөдөлмөрийн улсын хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

15. Байцаагчийг байгууллага, аж ахуйн нэгжийн захиалга, дуудлагаар хяналт шалгалт, туршилт, ослыг судлан бүртгэх, дүгнэлт гаргах ажилд оролцуулбал тэдний зардал /унаа, байр, болон бусад холбогдох/-ыг захиалга, дуудлагаар ажиллуулсан байгууллага хариуцна.

16. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно. Уг гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэртэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно.

Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

17. Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлтэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 11 дүгээр  
сарын 1-ний өдөр

Дугаар 194

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10, Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 7,8, Дээд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дотоод, гадаадын мэргэжлийн сургуульд суралцагчдыг төлбөртэйгээр суралцуулж байхаар тогтоосугай.

2. Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцагчийн сургалтын зардлыг төрөөс хариуцан санхүүжүүлэх журам"-ыг 1 дүгээр хавсралтын, "Мэргэжлийн сургуульд суралцагчдад хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж олгох журам"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталж 1995/1996 оны хичээлийн жилээс эхлэн мөрдүүлсүгэй.

3. Шинжлэх ухаан, боловсролын сайд С. Төмөр-очирт даалгах нь:

а/ сургалтын төрийн сангийн зээлээр болон хувийн зардлаар суралцаж байсан төрийн албан хаагчийн гэр бүлийн нэг хүүхдийн сургалтын зардлыг 1995/1996 оны хичээлийн жилээс эхлэн энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан журамд нийцүүлэн санхүүжүүлж, тэдний урьд авсан зээлийн төлбөрийг хуучин журмын дагуу нөхөн төлүүлэх арга хэмжээ авсугай;

б/ төрийн албан хаагчийн бус гэр бүлээс зээлээр суралцаж байсан суралцагчдад хүсвэл энэ тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журмын дагуу зээл олгож байсугай.

4. Сургалтын төрийн сангийн ажлын аппаратыг татан буудгаж суралцагчдад хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж олгох хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, зээлээр олгосон хөрөнгийг буцааж төлүүлэх, тайлагнах үйл ажиллагааг эрхлүүлэх үүрэгтэй сургалтын төрийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Шинжлэх ухаан, боловсролын ламны үндсэн бүрэлдэхүүнээр гүйцэтгүүлэхээр тогтоож, цалингийн санг баталж өгөхийг Шинжлэх ухаан, боловсролын сайд С. Төмөр-Очир, Сангийн сайд Э. Бямбажав нарт үүрэг болгосугай.

5. Төрийн албан хаагчийн гэр бүлийн нэг хүүхдийн сургалтын зардлыг жил бүрийн төсөвт тооцон тусгаж байхыг төсвийн шууд захирагч нарт, уг зардлыг нэгтгэн хянаж улсын төвлөрсөн болон

орон нутгийн төсөвт тусгаж байхыг Сангийн слайд Э. Бямбажав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасутай.

6. Төрөөс зардлыг нь хариуцан мэргэжлийн сургуульд суралцуулж байгаа төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцагчдын болон хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авч мэргэжлийн сургуульд суралцагчдын тоо, зардалын тухай мэдээг жилд 2 удаа гаргаж байхыг Шинжлэх ухаан, боловсролын яам /С. ТӨМӨР-ОЧИР/, Улсын статистикийн газар /Б. ЦЭНД-АЮУШ/-т үүрэг болгосутай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1992 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн "Журам батлах тухай" 107 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Сангийн сайд

Э. БЯМБАЖАВ

Шинжлэх ухаан, боловсролын сайд

С. ТӨМӨР-ОЧИР

Засгийн газрын 1995 оны 194 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ГЭР БҮЛЭЭС СУРАЛЦАГЧИЙН СУРГАЛТЫН ЗАРДЛЫГ ТӨРӨӨС ХАРИУЦАН САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмыг өмчийн бүх хэлбэрийн их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн дунд сургууль /цаашид "мэргэжлийн сургууль" гэнэ/-д төрийн албан хаагчийн гэр бүлээс элссэн нэг хүүхэд /цаашид "суралцагч" гэнэ/-ийн сургалтын зардлыг төрөөс хариуцан санхүүжүүлэхэд мөрдөнө.

2. Мэргэжлийн сургуульд Боловсролын тухай хуулийн дагуу сургалтын ажил эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бөгөөд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрмийн дагуу элсэлтийн шалгалтыг зохион байгуулж оюутан, сурагч элсүүлсэн өмчийн бүх хэлбэрийн их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн дунд сургуулиуд хамаарна.

3. Суралцагч нь мэргэжлийн сургуульд элсэн суралцах эрхийг тогтоосон журмын дагуу олж авсан байна.

4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн сургуулиуд дараагийн хичээлийн жилд элсүүлэх элсэгчдийн тоо, сургах мэргэжлийн захиалгыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5. Дараагийн хичээлийн жилд мэргэжлийн сургуулиудад элсүүлэх хүүхдийн тоо, сургах мэргэжлийн жагсаалтыг энэ журмын 4 дүгээр зүйлийн дагуу ирүүлсэн захиалгыг үндэслэн боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хянаж санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр Шинжлэх ухаан, боловсролын яам, Үндэсний хөгжлийн газраас баталж мэргэжлийн сургуулиудад хүргүүлнэ.

6. Суралцагчийн сургалтын зардлыг төрөөс хариуцан санхүүжүүлэх хугацаа нь тухайн мэргэжлийн сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг эзэмшүүлэхээр боловсрол хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацаагаар тогтоогдоно.

7. Төрийн албан хаагчийн гэр бүлд Монгол Улсын төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төрийн албан тушаалын ангилал, төрлийг үндэслэн Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалыг хашиж байгаа эцэг, эх хамаарна.

8. Төрийн албан хаагчийн гэр бүл нь төрөөс зардлыг нь хариуцан сургах нэг хүүхдээ өөрөө сонгоно.

### Хоёр. Сургалтын зардлыг санхүүжүүлэх

9. Суралцагчийн төрөөс хариуцан санхүүжүүлэх сургалтын зардалд багш, хичээлийн туслах ажилтны цалин, нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлс, тэдгээрээс тооцох бүх төрөл /нийгмийн даатгалын, эрүүл мэндийн даатгалын зэрэг/-ийн шимтгэл, ном хэвтэл, сургалтын хэрэгсэл худалдан авах, сургалтын материал хэвтэн олшруулах, үйлдвэртэлийн дадлага, судалгааны ажлын шууд зардал багтана.

10. Суралцагчийн төрөөс хариуцан санхүүжүүлэх сургалтын зардлын хэмжээг тухайн мэргэжлийн сургуулийн зэрэглэл, суралцагчийн эзэмших мэргэжил зэргийг харгалзан ангийн ялгавартайгаар боловсролын болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага замтран хичээлийн жилээр жил бүрийн 5 дугаар сарын 15-ны дотор тогтооно.

Хувийн сургуульд суралцагчийн сургалтын төлбөрийг төрийн өмчийн адилтгах сургууль, мэргэжлээр суралцагчийн сургалтын төлбөрийн жишгээр тогтооно.

11. Суралцагчийн эцэг /эх/ хүүхдээ тухайн мэргэжлийн сургуульд элссэнээс хойш нэг сарын дотор суралцагчийн зардлыг хэнийхээ нэр дээр төрөөр хариуцуулан санхүүжүүлэх тухайг ажиллаж буй албан байгууллагатайгаа тохиролцон гэрээ байгуулж, карт нээлгэн тушаалаар баталгаажуулна.

12. Суралцагч хүндэтгэх шалтгаангүйгээр сургуулиа орхисон, сурлага, сахилга батаар тэнцээгүйн улмаас сургалтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд төрөөс хариуцан санхүүжүүлсэн хөрөнгийг эргүүлж төлөх тухай эцэг /эх/ нь баталгаа гаргаж, төлбөрийг барагдуулах хугацааг гэрээгээр баталгаажуулна. Гэрээний үлгэрчилсэн загварыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

13. Суралцагч элссэн сургуульдаа бүртгүүлэх үед түүний тухайн жилийн сургалтын зардлын төлбөр мэргэжлийн сургуулийн дансанд төлөгдсөн байна.

14. Суралцагч сургалтын зардлын төлбөрийг өөрөө төлсөн тохиолдолд мөнгө тушаасан баримт, суралцагч, элсэлтийн тоо, мэргэжлийн захиалгад багтсан тухай сургуулийн тодорхойлолтыг үндэслэн эцэг, эхийн ажиллаж буй байгууллага нь зардлыг нөхөн олгоно.

15. Мэргэжлийн сургуульд суралцагч нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцсан тухайг эцэг, эхийн хоёулангийнх нь иргэний паспортод "нэг хүүхдийн зардлыг төр хариуцсан" гэсэн тэмдэглэгээг сургалтын зардлыг төлсөн байгууллага тушаалаа үндэслэн нэгэн зэрэг хийнэ.

16. Төсвийн шууд захирагч төрийн албан хаагчийн гэр бүлээс мэргэжлийн сургуульд суралцаж байгаа нэг хүүхдийн сургалтын зардлыг жил бүрийнхээ төсөвт тооцон тусгаж, харьяалах санхүүгийн байгууллагатай тооцоо хийж байна.

17. Суралцагчийн сургалтын зардлыг төрийн албан хаагчийн төрийн албан тушаал эрхэлж байгаа хугацаанд нь олгоно. Харин төрийн албанаас өөрчлөгдвөл суралцагчийн сургалтын зардлын санхүүжилтийг эзэлийн буюу бусад хэлбэрт шилжүүлднэ.

18. Суралцагч хүүхэд төрүүлсэн, өвчилсний улмаас холбогдох хууль тогтоомжийн дагуу чөлөөтэй байх хугацааны сургалтын зардлын санхүүжилтийг түр гүдгэлзүүлж үргэлжлүүлэн суралцахад нь зардлын санхүүжилтийг олгоно.

19. Суралцагчийн сургалтын зардлын санхүүжилттэй холбогдох маргалдагч талуудын хооронд гарсан маргааныг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага материалыг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан шийдвэртэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

20. Төрийн албан хаагчийн гэр бүлийн нэг хүүхэд зохих журмын дагуу элсэлтийн шалгалт өгч, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гадаад орны мэргэжлийн сургуульд суралцвал сургалтын зардлыг дотоодын мэргэжлийн сургуулийн жишгээр тооцож дараахь байдлаар зохицуулна:

а/ суралцагч нь Засгийн газар хоорондын хэлэлцээрээр оюутан солилцох хэлбэрээр суралцвал түүний эцэг /эх/-ийг ажиллуулж байгаа байгууллага сургалтын зардлын төлбөрийн тооцоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /сургалтын төрийн сан/-тай хийнэ;

б/ гадаад орны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр суралцвал сургалтын төлбөрийг давхардуулан олгохгүй;

в/ төлбөртэйгээр суралцсан тохиолдолд сургалтын төлбөр нь дотоодын адилтгах мэргэжлийн сургуулийн сургалтын зардлын жишгээс илүү байвал зөрүүг нь сургалтын төрийн сангаас эзэлээр олгох буюу суралцагч өөрөө хариуцна.

#### Гурав. Бусад асуудал

21. Суралцагчийн сургалтын зардлыг буруу олгосон төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нараар учруулсан хохирлыг хууль тогтоомжийн дагуу төлүүлнэ.

22. Суралцагчийн эцэг, эх сургалтын төлбөрийн талаар хуурамч материал бүрдүүлсэн, хүүхдээ сургуулиас хасагдсаныг нуун дарагдуулсан, төлбөрийг нь давхардуулан авсан зэрэг зөрчил гаргавал зохих хууль тогтоомжийн дагуу тэдэнд хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 1995 оны 194 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

### МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДАД ХӨНГӨЛТГЭЙ ЗЭЭЛ, БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмыг өмчийн бүх хэлбэрийн их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн дунд сургууль /шаахид "мэргэжлийн сургууль" гэнэ/-д суралцагчдад хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж олгоход мөрдөнө.

2. Мэргэжлийн сургуульд Боловсролын тухай хуулийн дагуу сур-



галтын ажил эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрмийн дагуу элсэлтийн шалгалтыг зохион байгуулж оюутан, сурагч элсүүлсэн өмчийн бүх төрлийн их, дээд сургууль, коллеж тусгай мэргэжлийн дунд сургуулиуд хамаарна.

3. Сургалтын зардалд багш, хичээлийн туслах ажилтны цалин, нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлс, тэдгээрээс тооцох бүх төрөл /нийгмийн даатгалын, эрүүл мэндийн даатгалын зэрэг/-ийн шимтгэл, ном хэвлэл, сургалтын хэрэгсэл худалдан авах, сургалтын материал хэвлэн олшруулах, үйлдвэрлэлийн дадлага, судалгааны ажлын шууд зардал багтана.

4. Сургалтын зардалын хэмжээг тухайн мэргэжлийн сургуулийн зэрэглэл, суралцагчийн эзэмших мэргэжил зэргийг харгалзан ангийн алгавартайгаар боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хичээлийн жилээр жил бүрийн 5 дугаар сарын 15-ны дотор тогтооно.

5. Суралцагчдын хөнгөлөлттэй эзэл, буцалтгүй тусламжид зориулан олгох хөрөнгийг төвлөрүүлэн бүрдүүлэх, эргэн төлүүлэх, тайлагнах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /сургалтын төрийн сан/ хариуцна.

### **Хоёр. Хөнгөлөлттэй эзэл олгох**

6. Мэргэжлийн сургуульд элсэн суралцах эрхийг тогтоосон журмын дагуу олж авсан суралцагчдад дараахь зардлыг төлөхөд зориулан хөнгөлөлттэй нөхцөлөөр эзэл олгоно:

а/ Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн буюу хагас өнчин суралцагчийн сургалтын төлбөр;

б/ магистрантын сургалтын төлбөр, багшийн мэргэжлээр суралцагчийн тэтгэлэг;

в/ гадаад орны мэргэжлийн сургуульд суралцагчийн сургалтын төлбөр, замын зардал;

г/ бага орлоготой өрхийн суралцагчийн сургалтын төлбөр.

7. сургалтын төрийн сангаас эзэл авах суралцагч нь дараахь материалыг бүрдүүлнэ:

а/ мэргэжлийн сургуульд элссэн тухай томилолт, суралцагчийн өөрийн нь болон эцэг /эх/ буюу асран хамгаалагчийн өргөдөл, эзэлийг эргүүлэн төлөх албан ёсны баталгаа;

б/ магистрантаар суралцуулах тухай мэргэжлийн сургуулийн захирлын тушаал, төгссөний дараа ажиллах байгууллагатай хийсэн гэрээ;

в/ гадаадын мэргэжлийн сургуульд суралцуулах тухай боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгаал, эзэл авахыг хүссэн суралцагчийн өөрийн нь болон эцэг /эх/ буюу асран хамгаалагчийн өргөдөл, эзэлийн төлбөрийн баталгаа;

г/ Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаат түвшингээс доош орлоготой суралцагчийн эцэг /эх/, асран хамгаалагчийн харьяалах сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт.

8. Эзэлээр суралцагч бүр эзэлийн дэвтэр, эзэлийн карттай байна.

9. Сургалтын төрийн сан энэ журмын 7-д дурдсан материалыг үндэслэн суралцагчтай гэрээ байгуулж, жил бүрийн 8 дугаар сарын 25-ны дотор сунгалт хийж байна.

"Сургалтын төрийн сангаас суралцагчдад эзэл олгох гэрээ"-ний загварыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

10. Суралцагчийн эзэлийг сургуульд нь бэлэн бусаар шилжүүлдэг. Мэргэжлийн сургуулийн нягтлан бодогч нар Сургалтын төрийн сангаас төлсөн сургалтын төлбөрийн хэмжээгээр суралцагч бүрийн эзэлийн дэвтэр, эзэлийн картад нэгэн зэрэг бичилт хийж хичээлийн жилийн I, II улирлын эцэст уг сангай тооцоо нийлнэ.

11. Эзэл нь мэргэжлийн сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг эзэмшүүлэхээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон хугацаанд хүүгүй байна. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалт гадаадад суралцах оюутны гэрээнд заасан анхны хугацаанд хамаарна.

12. Суралцагчдаар хөнгөлөлттэй эзэлийг сургууль төгссөнөөс нь хойш 1 жилийн дараагаас эхлэн дараахь хүүтэйгээр төлүүлдэг:

а/ Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой буюу хагас өмчин суралцагчийн сургалтын төлбөрийн эзэл сард 1 хувь;

б/ багшийн мэргэжлээр суралцагчийн тэтгэлгийн эзэл сард 2 хувь;

в/ магистрант болон бусад суралцагчдад олгосон эзэл сард 3 хувь.

13. Суралцагч авсан эзэлийг хүүгийн нь хамт сургуулиа төгссөнөий дараахь 6 хүртэлх жилийн дотор, харин магистрант 3 хүртэлх жилд багтаан төлж барагдуулна.

Хэрэв дээрх хугацааг хэтрүүлбэл төлөгдөөгүй эзэлийн хүүг арилжланы банкны тухайн үед мөрдөгдөж байгаа хугацаа хэтэрсэн эзэлийн төлбөрийн нөхцөлийг баримтлан төлүүлдэг.

14. Суралцагч хүүхэд төрүүлсэн болон өвчний улмаас холбогдох хууль тогтоомжийн дагуу чөлөө авснаас бусад шалтгаанаар цаашид

суралцахгүй болсон тохиолдолд эзэлийг зогсооно.

Эзэлийг зогсоосны дараахь сарлаас эхлэн сарын 3 хувийн хүүтэйгээр 2 жилийн дотор төлүүднэ.

15. Сургалтын төлбөр болон тэтгэлгийн эзэлийн хүүг дараахь тохиолдолд хөнгөлнө:

а/ суралцагч сургуулиа төгсөөд үндсэн мэргэжлээрээ төрийн албанд 5 жил ажиллавал эзэлийн хүүг 100 хувь, 3 жил ажиллавал 50 хувь;

б/ суралцагч эзэлээ сургуулиа төгссөний дараахь эхний жилд төлж барагдуулбал 100 хувь, хоёр жилд 50 хувь, гурав дахь жилд 25 хувь.

16. Багшийн мэргэжлээр төгсөгч мэргэжлээрээ 6-гаас доошгүй жил ажиллавал тэтгэлгийн эзэлийг бүрмөсөн чөлөөлнө.

17. Суралцагч нас барсан болон тахир дутуугийн I, II зэрэг тогтоогдсон нөхцөлд эзэлийн төлбөрийг хүүгийн хамт чөлөөлнө.

#### Гурав. Суралцагчдад буцалтгүй тусламж олгох

18. Мэргэжлийн сургуульд суралцагч бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, тахир дутуу хүүхдийн дараахь зардалыг төр харууцан буцалтгүй тусламжийн хэлбэрээр санхүүжүүлнэ:

а/ сургалтын зардал, тэтгэлгийг сургалтын төрийн сангаас олгох;

б/ дотуур байраар үнэ төлбөргүй хангах.

19. Мэргэжлийн сургуульд суралцаж буй амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн буюу хагас өнчин суралцагчид төрийн сангаас тэтгэлэг олгоно.

20. Суралцагчид буцалтгүй тусламжаар олгох төлбөр, тэтгэлгийг сургалтын төрийн сангаас сургуульд бэлэн бусаар шилжүүлднэ. Харин тэтгэлгийг сургуулиас нь бэлнээр олгоно.

21. Буцалтгүй тусламжийг бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, тахир дутуу, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн буюу хагас өнчин суралцагч болохыг нотолсон харьяалах сум, дүүргийн Засаг даргын албан ёсны тодорхойлолт, хувийн өргөдөл зэргийг үндэслэн олгоно.

22. Сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчдад нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийг хөнгөлөх буюу бусад хэлбэрээр хөхүүлэн дэмжихийг сургуулийн захиргаа өөрөө шийдвэрлэж санхүүжүүлнэ.

23. Суралцагчдын хөнгөлөлттэй эзэл, буцалтгүй тусламжийн санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 11 дүгээр  
сарын 1-ний өдөр

Дугаар 195

Улаанбаатар  
хот

**Иргэний эрүүл мэндийн болон  
нийгмийн даатгалын талаар авах  
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 6 дугаар зүйл, Нийгмийн даатгалын тухай хуулийн 3,9,24 дүгээр зүйлийг үндэслэн, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, даатгалын сангуудын бүрдэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Иргэний эрүүл мэндийн даатгалыг 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт шилжүүлж, үүнтэй холбогдуулан эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд зориулан бэлтгэсэн үндсэн хөрөнгийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүтээлгэн өгөх ажлыг энэ оны 12 дугаар сард багтаан дуусгах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П. Нямдаваа, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав, Сангийн сайд Э. Бямбажав нарт даалгасугай.

2. Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, даатгалд хамрагдагчдын хүрээг өргөтгөх, даатгалын сангуудын орлогыг хутагаанд нь бүрэн оруулах, зориулалтаар нь зарцуулахад тавих хяналтыг эрс сайжруулж, тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгоход холбогдох байгууллагуудын хүнийг бүрэн чиглүүлж ажиллахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангуудын бүрдэлт, зарцуулалтын байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн талаар 1996 оны 4 дүгээр сард Засгийн газарт танилцуулахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожавт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Монгол Улсын

Засгийн газрын 1993 оны 133 дугаар тогтоолын 5,7 дугаар заалтуудыг 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд	П. ЖАСРАЙ
Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд	Э. ГОМБОЖАВ
Сангийн сайд	Э. БЯМБАЖАВ
Эрүүл мэндийн сайд	П. НИЯМДАВАА

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 11 дүгээр  
сарын 3-ны өдөр

Дугаар 196

Улаанбаатар  
хот

Хүүхдийн зарим сонин, сэтгүүлийн  
талаар авах арга хэмжээний тухай

"Хүүхдийн соёл, хүмүүжил, халамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 119 дүгээр зарлигийн нэгдүгээр зүйлийн "в" заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам (Э. ГОМБОЖАВ), Шинжлэх ухаан, боловсролын яам (С. ТӨМӨР-ОЧИР)-д даалгах нь:  
а/ хүүхдийн "Хойчийг залгамжлагч" сонин, "Залгамжлагч", "Оюунгүлхүүр" сэтгүүлийг 1995 оны 4 дүгээр улирлаас тогтмол хэвлэн гаргаж байсугай;

б/ хүүхдийн хэвлэлийн талаар баримтлах бодлогыг тодорхойлж, дээрх сонин, хэвлэлийг хүүхдийн оюуны эрэлт хэрэгцээ, нас сэтгэхүйн онцлог, хүсэл сонирхолд нийцүүлэн чанар, өнгө үзэмж сайтай хэвлэн гаргахын зэрэгцээ тэдгээрийн хэвлэгдэх тоог нэмэгдүүлэх, өртөг зардалыг бууруулах замаар орлогоороо зардлаа нөхөж ажиллахад чиглэсэн арга хэмжээ авч ажилласугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлийн "а"-д дурдсан сонин, сэтгүүлийг хэвлэхтэй холбогдсон зардалыг хянаж, зардлын зарим хэсгийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны харьяа Хүүхдийн төлөө

үндэсний төв, Шинжлэх ухаан, боловсролын яамны жилийн төсөвт тус тус тусган санхүүжүүлд байхыг Сангийн яам (Э. БЯМБАЖАВ)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд	П. ЖАСРАЙ
Сангийн сайд	Э. БЯМБАЖАВ
Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд	Э. ГОМБОЖАВ
Шинжлэх ухаан, боловсролын сайд	С. ТӨМӨР-ОЧИР

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 11 дүгээр  
сарын 3-ны өдөр

Дугаар 198

Улаанбаатар  
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам, жагсаалт батлах тухай" БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 260 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үйлдвэртэл, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгох журам"-ын хавсралтын "Аж ахуйн нэгжээс зөвшөөрөлтгэйтгээр эрхлэн гүйцэтгэж болох үйлдвэртэл, үйлчилгээний жагсаалт"-д "27. Шингэрүүлсэн шатдаг хийн үйлчилгээ эрхлэх-Эрчим хүч, геологи, уул уурхайн яам" гэсэн нэмэлт өөрчлөлт оруулсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд	П. ЖАСРАЙ
Эрчим хүч, геологи, уул уурхайн сайд	Б. ЖИГЖИД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 11 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 208

Улаанбаатар  
хот

Тогтоолын заалтат нэмэлт, өөрчлөлт  
оруулах, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 153 дугаар тогтоолын зөвлөлийн бүрэлдэхүүний хэсэгт "Засгийн газрын хяналтын түшмэл" гэснийг "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажилтан" гэж өөрчлөн, зөвлөлийн орлогч даргад: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, гишүүдэд: Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн судалгааны төвийн захирал /Улсын дээд шүүхтэй зөвшилцсөнөөр/, Улсын прокурорын газрын ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих албаны дарга /Улсын Ерөнхий прокурортой зөвшилцсөнөөр/, Батлан хамгаалахын дэд сайд бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, Байгаль орчны дэд сайд, Соёлын дэд сайд, Эрүүт мэндийн дэд сайд, Гаалийн ерөнхий газрын дарга, Хилийн цэргийг удирдах газрын дарга, Сангийн яамны санхүүгийн хяналт шалгалтын албаны дарга гэж нэмсүтэй.

2. "Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих зөвлөлийн ажиллах журмыг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд

Л. ЭНЭБИШ

Хууль зүйн сайд

Н. ЛУВСАНЖАВ

**"МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ ХАНГАХ  
ТАЛААР ТӨРӨӨС ЯВУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛЖ ХЯНАЛТ ТАВИХ ЗӨВЛӨЛИЙН  
АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. "Монгол улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих зөвлөл /шаашид "зөвлөл" гэх/-өөс Монгол Улсын Их Хурлын 1992 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл", 1995 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Нийгмийн дэг журмыг хангах талаар авах арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх талаар төрийн төв болон нутгийн захиргаа, хууль хяналтын болон өөрөө удирдах байгууллагуудаас хийх ажлыг уялдуулан зохицуулах, явц байдлыг нэгтгэн дүгнэлт гаргах, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан бөгөөд хуралдаанаар зөвлөлийн үүрэг зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үндсэн асуудал, нийгмийн дэг журам хангах талаар зохиох ажлын төлөвлөгөөний төсөл, биелэлтийн явц, үр дүн, зөвлөлийн ажлын тайланг хэлэлцэнэ. Зөвлөлийн хуралдааныг ажлын шаардлагыг харгалзан зөвлөлийн даргын шийдвэрээр хийж байна.

Зөвлөл нь хуралдааны үйл ажиллагааны талаар тэмдэглэл хөтөлж түүнд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.

Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг яам, тусгай газар, нутгийн захиргааны байгууллага биелүүлэх үүрэгтэй.

3. Зөвлөл нь үйл ажиллагаагаа явуулахдаа Засгийн газрын болон түүний Хэрэг эрхлэх газрын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдгийг хэрэглэнэ.

**Хоёр. Зөвлөлийн үүрэг, эрх**

4. Зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ Монгол Улсын Их Хурлын 1992 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс



явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл", 1995 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Нийгмийн дэг журам хангах талаар авах арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас хийх ажлыг уялдуулан зохицуулах, явц байдлыг нэгтгэн дүгнэлт гаргах, дүнг улирал бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байх;

б/ тухайн үед олны анхаарлыг татаж нийгэм, иргэдэд бусдаас илүүтэй хохирол учруулж байгаа тодорхой төрөл /иргэдийн амь нас, эрүүл мэнд, төрийн болон иргэдийн өмч хөрөнгөд халдах, архидан согтуурах, танхайрах, албан тушаал ашиглах зэрэг/-ийн гэмт хэрэг-гэй тэмцэх, түүнийг таслан зогсоох талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас зохиож байгаа ажлын явц, үр дүнгийн байдлыг нэгтгэн дүгнэж байх;

в/ нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрийн төв болон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагууд, хууль хяналтын байгууллагуудаас зохиож байгаа ажлыг уялдуулан зохицуулж, хамтач ажиллагааг нь дээшлүүлэх арга хэмжээ авч, энэ ажлын явц, үр дүнг шалган зааварчилж байх;

г/ гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэхтэй холбогдсон гөө, засгийн дээд байгууллагаас гаргах шийдвэрийн төслийг боловсруулан холбогдох газруудад оруулах ажлыг зохион байгуулах;

д/ үндэсний уламжлалт хүмүүнлэг ёс, заншлыг сэргээхтэй холбогдсон арга хэмжээг авахуулах ажлыг зохицуулах;

е/ нийгмийн дэг журам хангах талаар байгууллага, иргэдээс аргасан санал, бодлыг судлан түүний мөрөөр асуудал боловсруулан сэргээхтэй ажилд хяналт тавих;

ж/ нийгмийн дэг журам хангахад албан байгууллага, аж ахуйн тэгж, олон нийтийн байгууллага, иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжин тэднийг энэ ажилд өргөн хэмжээгээр оролцуулж, дэмжлэг тусалцаа үзүүлэх;

з/ нийгмийн дэг журам, сахилга зохион байгуулалтыг бэхжүүлэх, хууль сахин биелүүлэх талаар төрөөс явуулж буй бодлогыг олон үмэнд хүргэж сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;

и/ нийгмийн дэг журам хангах аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний ажлыг шалган зааварлаж, чиглэл заалт өгөх;

к/ нийгмийн дэг журам хангахтай холбогдсон улс, орон нутгийн чанартай семинар, хурал, зөвлөлгөөн зохион байгуулах;

л/ гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй холбогдсон мэдээ тайланг зохиох газруудаас гаргуулан авч судалгаа хийж дүгнэлт гарган холбогдох арга хэмжээ авахуулах;

м/нийгмийн дэг журам хангах талаар төрийн төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас зохиож байгаа ажлын тайланг хагас, бүтэн жилээр гаргуулан авч нэгтгэн зөвлөлийн хуралдаанаар цаашид авах арга хэмжээний хамт хэлэлцэж тэдгээр байгууллагуудын ажлын үр дүн, арга барилын талаар мэдээлэл бэлтгэн сурталчилж байх;

н/ нийгмийн дэг журам хангах талаар Засгийн газар, Зөвлөлөөс зохиож байгаа ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон түмэнд сурталчлах ажлыг зохион байгуулах.

5. Зөвлөл нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/ нийгмийн дэг журам хангахтай холбогдсон зайлшгүй шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулж авах;

б/ зарим шаардлагатай асуудлаар дүгнэлт гаргах, асуудал боловсруулах, үзлэг шалгалт хийх зэрэгт мэргэжлийн хүмүүсийг холбогдох төрийн захиргааны байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр тодорхой хугацаагаар үүрэгт ажлаас нь түр чөлөөтүүлэн оролцуулах;

в/төв орон нутагт төр, олон нийт, аж ахуйн болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэдээс "Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл", "Нийгмийн дэг журмыг хангах талаар авах арга хэмжээний төлөвлөгөө", холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, энэ чиглэлээр зохиож байгаа ажилд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавих, шалгах ажлыг зохион байгуулах;

г/ нийгмийн дэг журам, сахилга, зохион байгуулалтыг бэхжүүлэх талаар холбогдох байгууллага албан тушаалтанд үүрэг, даалгавар өгч, биелэлтийг гаргуулах;

д/ шаардлагатай гэж үзвэл эрх хэмжээний асуудлаар яам, тусгай газар, тэдгээрийн харьяа байгууллага, нутгийн захиргааны болон аж ахуйн байгууллага, албан тушаалтны илтгэл, сонсголыг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн заалт, чиглэл өгөх;

е/ нийгмийн дэг журам хангах талаар гарсан хууль тогтоомж, төр, засгийн дээд байгууллагын шийдвэр, даалгаврыг биелүүлээгүй буюу хагас дутуу, чанаргүй биелүүлсэн албан тушаалтанд хөдөлмөрийн болон төрийн албаны хуульд заасан шийтгэл ногдуулах тухай саналаа холбогдох байгууллагад оруулах.

**Гурав. Орон нутгийн салбар зөвлөл**

6. Нийгмийн дэг журам хангах үүргийг орон нутагт хэрэгжүүлэх

жлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нараар ахлуулсан орон нутгийн салбар зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.

7. Орон нутгийн салбар зөвлөл нь энэхүү журмыг үндэслэн нутаг гэвсгэрийн онцлогийг тусгасан журам гарган түүнээ мөрдөн нийгмийн дэг журам хангахтай холбогдсон төр, засгийн хууль тогтоомж, тэд шатныхаа зөвлөлийн шийдвэрийг биелүүлдэг ажиллана.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 11 дүгээр  
арын 11-ний өдөр

Дугаар 210

Улаанбаатар  
хот

Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний  
улсын хяналтын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Худалдааны улсын хяналтын дүрэм батлах тухай" БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 118 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Худалдаа, үйлдвэрийн сайд

Ц. ЦОГТ

Засгийн газрын 1995 оны 210 дугаар  
тогтоолын хавсралт

## ХУДАЛДАА, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын зорилт нь Монгол Улсын хэмжээнд худалдаа, үйлдвэр, үйлчилгээний талаар иргэсэн Монгол Улсын хууль тогтоомж, түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм,

журмын хэрэгжилтийг байгууллага, аж ахуйн нэгжийн харьяалал өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төрийн захиргааны хяналт тавьж биелэлтийг хангуулахад оршино.

2. Улсын хяналтыг худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын алба, аймаг, нийслэлийн худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

3. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын албаны дарга нь улсын ерөнхий байцаагч байна. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын ерөнхий байцаагчийг худалдаа, үйлдвэр, үйлчилгээний асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

4. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор худалдаа, үйлдвэр үйлчилгээний асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө.

Аймаг, нийслэлд ажиллах худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж чөлөөлөх бөгөөд тэдгээр байцаагчийн эрхийг худалдаа, үйлдвэр үйлчилгээний асуудал эрхэлсэн сайд олгоно.

5. Ажил төрлийн онцлог байдлаас зарим яам, тусгай газарт худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын байцаагч ажиллуулах болно. Яагч, тусгай газарт ажиллах улсын байцаагчийг сайд, тусгай газрын дарга нар нь томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр байцаагчийн эрхийг худалдаа, үйлдвэр, үйлчилгээний асуудал эрхэлсэн сайд олгоно.

6. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын байцаагчид нь худалдаа, үйлдвэр, үйлчилгээний асуудлаар мэргэшсэн байна.

7. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын алба, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

8. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын ерөнхий болон ахлах байцаагч, улсын байцаагчид /шашид энэ дүрэмд "байцаагч" гэх/ нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

9. Аймаг, нийслэлд ажиллаж байгаа байцаагчийг мэргэжил, аргачлалын удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санаа боловсруулж шийдвэрдүүлэхийг Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын алба харнууцан хэрэгжүүлнэ.

**Хоёр. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын  
хяналтын чиглэл**

10. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтыг дор дурасан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт, нийлүүлэлт, борлуулалт, худалдалалт, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдон гарсан хууль тогтоомж, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний асуудал эрхэлсэн сайдын шийдвэр, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтны тогтоосон журмын хэрэгжилт;

б/ худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, технологийн горимд улсаас тогтоосон нийтлэг журмын шаардлага хангагдаж байгаа эсэх;

в/ гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийн биелэлт, зуучлалын үүрэг гүйцэтгэж байгаа гадаадын төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа гэрээ, гүрмийнхээ дагуу явагдаж байгаа эсэх;

г/ гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан аж ахуйн нэгж, байгууллагын гэрээ, хэлэлцээр, дүрмийн хэрэгжилт;

д/ улсын хилээр нэвтрүүлэх бараа, ажил, үйлчилгээнд олгосон мөвшөөрөл (лиценз)-ийн биелэлт;

е/ улсын нөөцийн бараа, бүтээгдэхүүний хадгалалт, нөхөн зургуулалт, зарцуулалт;

ж/ аялал, жуулчлалын талаар баримтлах бодлого түүний хэрэгжилт, зохион байгуулалт, үйлчилгээнд тавих хяналт;

з/ зочид буудал, нийтийн хоолны болон хүн амын ахуй үйлчилгээний газруудын үйл ажиллагааны байдал, технологийн шаардлагын хэрэгжилт;

и/ хэрэглээний аюулгүй байдлыг хангах үүднээс хүний амьнас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулж болзошгүй бараа, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, стандарт, чанарын баталгаагүй, ав, баглаа, боодол, шошгол олон улсын хэмжээнд нийтлэг хэрэгсдэг барааны таних тэмдэг, анхааруулга, бичээсийг ил тод тавиагүйгээр худалдах явдал гаргаж байгаа эсэх;

к/ бараа, бүтээгдэхүүний савталтыг зохих ёсоор хийх болон эмжүүр, хэмжих хэрэгслийг зориулалтын дагуу ашигласан эсэх, эрхлэгчдэд үнэн зөв хэмжин олгож байгаа эсэх;

л/ бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх арга, баталгаат хэрэглээний хугацааны болон түүнийг аюул осолгүй хэрэглэх талаар хэрэглэгчдэд үнэн өв, бүрэн мэдээлэл өгч байгаа эсэх;

м/ эрүүл ахуйн шаардлага хангаагүй байр орчин, худалда хийхийг зөвшөөрөөгүй газар, цэгт болон эмхэлгийн шинжилгээний баталгаагүй, насанд хүрээгүй, хуулийн хариуцлага хүлээх чадваргүй этгээдээр худалдаа, үйлчилгээг явуулж буй эсэх;

н/ бараа, бүтээгдэхүүнийг зориулалт бусаар худалдаалах, үн дэслэлгүйгээр нөөцлөх, нуун дарагдуулах, хориглосон худалдаа хий зэрэг зөрчил гаргаж хэрэглэгчдийг хохироож байгаа эсэх.

**Гурав. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын байшаагчийн үүрэг, эрх**

11. Улсын байшаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/ энэ дүрмийн 10 дугаар зүйлд заасан чиглэлийн дагуу улсын хяналтыг зохион байгуулж явуулах;

б/ хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд ү автах, албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтны хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүн дэтгэх, өөртэйгээ болон эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, са дан төрлийн хүмүүст холбогдох асуудлыг шалтгаалаас татгалзах, хяналт шалгалтыг бүрэн гүйцэд хийх;

в/ хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн акт, танилцуулгы албан шаардлага, тоо, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах.

12. Улсын байшаагч нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/ хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг тасла зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

б/ холбогдох байгууллагатай нь тохиролцож зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадла шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

в/ шалгалтад шаардлагатай мэдээ, судалгаа, магадлагаа, буса баримтын хуулбарыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэд, банк, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

г/ хийж байгаа хяналт шалгалтын асуудлаар болон хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар амаар буюу бичгээр тайлбар авах, ярианы бичлэг хийх;

д/ бүтээгдэхүүний дээж, загварыг тэмдэглэл үйлдэн захиргааны хяналтын эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо хэмжээгээ авах, шинжүүлэх.

е/ ноцтой осол гарсан, хүний амь, эрүүл мэнд, эд материалын хэзэхэн хохирол учруулсан болон зөрчил нь нийгмийн хор аюул их-  
 өй бол шалгалтын акт, материалыг хуулийн байгууллагад шилжүү-  
 гах;

ж/ хуурамч буюу хүчингүй гэрээ, хэлэлцээр, бусдын зөвшөө-  
 нөл (лиценз) худалдан авах хэлбэрээр гадаад худалдааны үйл ажил-  
 лагаа гүйцэтгэсэн байвал орлогыг хураах;

з/ шаардлагатай үед өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж,  
 айгууллагад саалгүй нэвтрэн орж мөнгө, эд хөрөнгийн зүйл хад-  
 алж байгаа байр, агуулах, үйлдвэртэлийн байранд үзлэг тооллого,  
 ехнологийн үйл ажиллагаанд шалгалт хийж холбогдох арга хэмжээ  
 авах;

и/ хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, аж ахуйн нэгж,  
 айгууллагын хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж  
 эсын орлогод оруулах;

к/ хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд ба  
 дууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох,  
 үүнчлэн осол аюул гарч болох нь зохих ёсоор нотлогдсон, чанарын  
 шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүн үйлдвэртэсэн, нийлүүлсэн,  
 үлгээн авсан, худалдсан болон худалдаа, үйлчилгээний дэг журам,  
 риун цэвэрийн шаардлагыг ноцгой зөрчсөн тохиолдолд холбогдох  
 жил, үйлдвэртэл, үйлчилгээ, үйл ажиллагааг уг зөрчлийг арилгах  
 үртэл бүхэлд нь эсвэл хэсэгчлэн түр зогсоох, шаардлагатай зүйлийг  
 риутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, бараа, бүтээгдэхүүнийг худал-  
 ах, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлах-  
 үй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон  
 нийтэд зарлан мэдээлэх;

л/ бараа, бүтээгдэхүүний үнийг үндэстэлгүй өсгөж худалдаал-  
 ан барааны үнийг улсын орлогод оруулах, буруутай этгээдэд ха-  
 ниуцлага ногдуулах.

13. Байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, илэрсэн  
 эрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэм бу-  
 уутай этгээдэд Монгол Улсын төрийн хяналт, шалгалтын тухай  
 ууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг  
 эмгэглэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн  
 салтыг үндэслэн дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

а/ хориглосон үйлдвэртэл, худалдаа, үйлчилгээ эрхэлсэн нь  
 рүүгийн хариуцлага хүтээлгэхээргүй бол хууль бусаар олсон орло-  
 г буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн  
 эгжийг 80000-250000, иргэнийг 10000-50000 төгрөгөөр  
 эрэх;

б/ зохих зөвшөөрөлгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулсан бол

хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийг 60000-150000, иргэнийг 500-20000 төгрөгөөр торгох;

в/ эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, шэг худалдаа, үйлчилгээ явуулсан бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийг 80000-200000, иргэнийг 1000-20000 төгрөгөөр торгох;

г/үйлдвэрлэгч, гүйцэтгэгч улсын стандартыг зөрчих, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг чанарын баталгаагүйгээр үйлдвэрлэж, худалдаж, импортлосон, ийм бүтээгдэхүүн хэрэглээнд гаргасан нь нотлогдсон тохиолдолд энэ тухайгаа үйлдвэрлэгч, худалдагч, олон нийтэд нэн даруй мэдээлээгүй иргэнийг 50000 хүртэл, байгууллага аж ахуйн нэгжийг 200000 хүртэл төгрөгөөр торгож, уг бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг хурааж улсын орлогод оруулах;

д/ үйлдвэрлэгч, худалдагч нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулж болзошгүй бүтээгдэхүүн, түүний сав, баглаа боодол, шошгод олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэдэг таних тэмдэг, бичээсийг ил тод тавиагүй, мөн ийм бүтээгдэхүүн болон түргэн муудаж, чанар байдалаа алддаг бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, ашиглах, хэрэглэхэд тавих шаардлагыг бүтээгдэхүүн ашиглаа зааварт тусгаагүй иргэнийг 40000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 140000 хүртэл төгрөгөөр торгох;

е/ үйлдвэрлэгч, худалдагчаас хэрэглэгчийг зориуд төөрөгдүүлсэн мэдээлэл хийсэн бол иргэнд 30000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжид 100000 хүртэл төгрөгийн торгууль ногдуулж, орлогыг хурааж улсын орлогод оруулах;

ж/ бүтээгдэхүүнийг хэрэглэгчид тулган худалдах, хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээний үндсэн дээр бүтээгдэхүүн борлуулсан буруутай худалдагчийн гэрээг хүчингүйд тооцож, олсон орлогыг хурааж улсын орлогод оруулах;

з/ улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч нар хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-10000, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүтээлгэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтныг 15000 хүртэл төгрөгөөр торгох;

и/ худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-25000, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан гартал дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон этгээдийг 35000 хүртэл, хяналт шалгалтын холбогдолтой баримт бичгийг гаргаж өгө-



хөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч бичиг баримт гаргаж өгсөн албан тушаалтныг 35000-50000 төгрөгөөр торгуулах асуудлыг шүүгчид тавьж шийдвэрлүүлэх.

### Дөрөв. Бусад асуудал

14. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлд, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

15. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо уг шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор тухайн шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана. Гомдлыг хүлээн авсан байгууллагын эрх баригч түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

16. Гомдол гаргах нь торгууль шийтгэврээр ногдуулсан төлбөр төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.

17. Улсын байцаагч энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй болон хууль, тогтоомж зөрчвөл зохих хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

---

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч	Н. Ринчиндорж
Нарийн бичгийн дарга Гишүүд	Сан. Жаргалсайхан Т. Баасансүрэн Ч. Бавуу Б. Ганбат Б. Янжиглхам
Техник редактор Уншиж хянасан	С. Итгэлт Сан. Жаргалсайхан Б. Янжиглхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1996 оны 3-р сарын 26-нд.  
Өрөлтөд 1996 оны 3-р сарын 26-нд. Хэвлэлтэд  
1996 оны 4-р сарын 16-нд. Хэвлэлийн хуудас 5,75.  
Хэвлэсэн тоо 4750 ширхэг.

Манай хаяг: Улаанбаатар-12  
Төрийн ордон. Утас:322838

Засгийн газрын хэвлэх үйлдвэр